



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Монгол Улсын Харилцаа Холбооны Зохицуулах Хороо (цаашид ХХЗХ гэх)-ноос тайлангийн хугацаанд байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа, ХХЗХ-ны Дарга /буюу Төсвийн шууд захирагч/ болон Монгол Улсын Ерөнхий сайд /буюу Төсвийн ерөнхийлөн захирагч/ нарын хооронд 2019 онд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний 6 ангилал, 27 бүлэг нийт 292 зорилт, арга хэмжээ, төлөвлөгөөт ажил болон удирдлагаас өгсөн чиглэл, үүрэг даалгавар, бусад ажлын хүрээнд арга хэмжээ (зохицуулалтын баримт бичиг, давтамжийн хуваарилалт, ашиглалт, төлбөрийн хэмжээ, төсөл хөтөлбөр)-ний талаар Даргын зөвлөл, Хорооны хуралдаанаар тус тус хэлэлцэн шийдвэрлэж, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэн зохион байгуулж ажилласан болно.

Харилцаа холбоо, мэдээллийн техник, технологийн ололт, шинэ төрлийн үйлчилгээ хэрэглээний их өгөгдөл, нээлттэй өгөгдөл, зүйлсийн интернэт, тооцоолол, хиймэл оюун ухаан зэрэг нь бусад салбарт ялангуяа цахим боловсрол, цахим эрүүл мэнд, цахим банк, ухаалаг хот, ухаалаг улс зэрэг шинэ дэд бүтцийг бүрдүүлж эхлээд байна. Энэ нь харилцаа холбооны салбарын үйлчилгээ, хэрэглээг нийгэм, эдийн засгийн бусад салбарт нэвтрүүлэхдээ сүлжээ, технологийн талаар салбар хоорондын уялдаа холбоог хангах, нэгдсэн бодлого төлөвлөлт, зохицуулалтаар хангахыг биднээс шаардаж байна.

Дижитал технологийн дэд бүтцэд суурилсан дижитал эдийн засгийн орчинг зүйлсийн интернэт бүрдүүлж, үүрэн холбооны 5 дахь үе, өндөр хурдны LTE утасгүй технологийн нэвтрэлт нь ухаалаг утас, интернетийн мэдээллийн хурдыг эрс нэмэгдүүлж, хэрэглээ үйлчилгээний хамрах хүрээ, хүртээмжийг өргөжүүлж байна. Хамгийн их хүлээлттэй байгаа зүйлсийн интернэтийн хувьд хэзээ ч, хаана ч, дурын сүлжээ, төхөөрөмжөөр бүх төрлийн үйлчилгээ, хэрэглээ, контентыг хүртэх хоорондоо үргэлж холбогдсон, холболтын орчинг бүрдүүлэх зорилготой.

Дижитал шилжилтийн үйл ажиллагаа нь технологи ба мэдээллийг үүсгэх, боловсруулах, хуваалцах, дамжуулах, хэрэгжүүлэх зэрэг бүхий л технологийн үйл ажиллагаанд тоон технологийг ашиглах нөхцлийг бүрдүүлэх үндсэн зорилготой юм. Дижитал шилжилтийн 3 дах давалгааны (Digital transformation-Digitalization wave: 3-rd Wave of Digitalization) орчин дахь харилцаа холбоо, мэдээллийн технологи, шуудан холбооны хөгжил өдөр хоногоор бус цаг хормоор хувьсан өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа нь салбарыг нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжсэн хэрэгсэл болгох, дэлхийн жишигт нийцсэн техник, технологийн ололт, хэрэглээ үйлчилгээг судлан цаг алдалгүй нэвтрүүлэх, хамрах хүрээ чанарыг дээшлүүлэх, бизнесийн болон өрсөлдөөний таатай орчинг бүрдүүлэхэд зохицуулах байгууллагын чиг үүрэг улам бүр нэмэгдэж, улс орон бүрийн өмнө шинэ сорилт болж байна.



Төрийн мэдээлэл солилцооны “ХУР”, “ДАН” цогц системийг хөгжүүлснээр нь төрийн мэдээлэл солилцооны систем хэрэглээнд бүрэн нэвтрэх, цахим засгийн нэгдсэн тогтолцоог бий болгох, нээлттэй орчинг бүрдүүлэх, төр, хувийн хэвшлийн үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээний чанар сайжирч, түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй, бүрэн цахим орчинд иргэд, байгууллагууд төрийн үйлчилгээг авах боломжийг бүрдүүлэхээр шат дараалсан арга хэмжээг ЗГХЭГ, ХХМТГ-тай хамтран ХХЗХ-ноос зохицуулалтын арга хэрэгслээр дэмжин ажилласан.

Тайлангийн хугацаанд буюу 2019 онд, ХХЗХ-ны 2019 оны ээлжит 12 удаа, ээлжит бус 2 удаагийн хуралдааныг зохион байгуулж, нийтдээ 120 гаруй асуудлыг хэлэлцэж хорооны хуралдаанаас баталсан 62 тогтоол, шийдвэр болон 20 хуралдааны тэмдэглэлийн нэгдсэн жагсаалтыг тайлангийн **хавсралт-1**-д нэгтгэн үзүүлэв. (2019 оны тогтоол, шийдвэрийн жагсаалтыг нэгтгэн үзүүлбэл):

- Зохицуулах хорооны үйл ажиллагаандаа хүчин төгөлдөр мөрдөж байгаа эрхзүйн хэм хэмжээний акт буюу зохицуулалтын чиглэл, дүрэм журам, нөхцөл шаардлага, давтамжийн хуваарилалт ба төлөвлөлтийн баримт бичиг-73;
- Захиргааны ерөнхий хууль, УИХ-аас 2019 оны 5 дугаар сард Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай хуульд тус тус оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлж, шинэчилэх, нэмэлт өөрчлөлт оруулан шинээр тогтоож баталсан 19;
- Зохицуулалтын баримт бичиг, давтамжийн хуваарилалт, нөхцөл шаардлага ХЗДХЯ-нд нийтээр даган мөрдөх хэм хэмжээнд хянуулан бүртгүүлэхээр албан тоотоор хүргүүлсэн ба ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн санд 9 баримт бичгийг бүртгүүлсэн болно.
- Шинээр болон шинэчлэн, нэгтгэн боловсруулж батлуулсан (техникийн нөхцөл шаардлага, давтамжийн хуваарилалт, баталгаажуулалт, зөвлөмж, үнэ тариф тогтоох)-17;
- Тогтоолын хавсралт болон тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулсан-2;
- Захиргааны ерөнхий хууль, УИХ-аас 2019 оны 5 сард Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай хуульд тус тус оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу шинэчлэн баталсан болон үйлчлэх хугацаа хугацаа дууссан, хүчингүй болгосон-32 баримт бичиг зэрэг болно.

Зохицуулах хорооноос Захиргааны ерөнхий хууль болон холбогдох хууль, тогтоомжид хорооны тогтоол, шийдвэрийг нийцүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлж байгаа бөгөөд энэхүү арга хэмжээний хүрээнд 2002 оноос хорооны хуралдаанаар баталсан 180 гаруй тогтоол, нэмэлт өөрчлөлтийг хянан үзэж, ЗЕХ, “Харилцаа холбооны тухай” (УИХ-аас 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан), “Шуудангийн тухай” (УИХ-аас 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан), “Радио долгионы тухай” (УИХ-аас 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан), Өргөн нэвтрүүлгийн тухай (УИХ-аар 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр баталсан) “Цахим гарын үсгийн тухай”, “Сонгуулийн тухай” болон холбогдох Монгол Улсын хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж эдгээр хуулиудад тусгайлан заасан эрх үүргүүдийг нийцүүлэх, шинэчлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, баталсан тогтоол шийдвэрийг ХЗДХЯ-д хүргүүлэн хянуулж, Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд бүртгүүлэн ажиллав.

Бүртгүүлсэн хорооны тогтоолыг хавсралтын хамт Захиргааны ерөнхий хуулийн дагуу эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (www.legalinfo.mn), хорооны цахим хуудас (www.crc.gov.mn)-д тус тус байршуулан ажилласан.

Тоон шилжилт, цахим засаглал, ухаалаг хэрэглээ, үйлчилгээг Монгол Улсын нийгэм эдийн засаг, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд харилцаа холбоо (холбоо, мэдээллийн технологи, шуудангийн)-ны салбарын хөгжлийн өнөөгийн хүрсэн түвшин, түүнд хийсэн мониторинг үнэлгээний үр дүн, олон улсын байгууллагын индикатор үзүүлэлтийг дүгнэж үзээд, харилцаа холбооны салбарын талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хорооны үйл ажиллагааны стратегиуд, зорилго, зорилтуудыг шинэчлэн тодорхойлох нь чухал ач холбогдолтой.

Зохицуулах хорооны 2019 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 01 тоот тогтоолын хавсралтаар **“Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019-2024 оны үйл ажиллагааны стратеги”**-ийг баталсан болно. Уг баримт бичигт Монгол хүн бүрийг орчин үеийн харилцаа холбооны дэвшилтэт үйлчилгээгээр хангах, дижитал эдийн засаг, “Мэдээлэлжсэн нийгэм”-ийн суурь үндсийг бүрдүүлэх, хөгжүүлэхэд зохицуулалтын дэмжлэг үзүүлэх замаар харилцаа холбоо, мэдээллийн технологийн ололтыг нийгэм, эдийн засгийн бүх салбар, хүн бүрийн өдөр тутмын хэрэглээ, хэрэгцээ шаардлага болгохоор заасан байна. Энэ хүрээнд тоон ялгааг бууруулж харилцаа холбооны дэвшилтэт үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх; хэрэглэгчийн эрх ашиг, нийтийн ашиг сонирхлын хамгаалах, гамшгийн үед нийтийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх; инновацийг дэмжиж, өрсөлдөөнийг төгөлдөршүүлэх замаар технологийн нэгдэн нийлэлтийг үр өгөөжийг нэмэгдүүлэх, тоон шилжилтийг хурдасгах; ХХЗХ-ны чадавхийг сайжруулах зэрэг 4 гол зорилтыг дэвшүүлж, холбогдох зорилго арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Энэхүү баримт бичгийн зорилгт, арга хэмжээг ХХЗХ-ны жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тухай бүр тусган батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллав.

Монгол Улсын Ерөнхий Сайд-Төсвийн Ерөнхийлөн захирагч болон Төсвийн шууд захирагч-Хорооны дарга нарын хооронд байгуулсан “Төсвийн шууд захирагчийн 2019 оны бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ”-ний тайланг нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Байгууллагын архивт ХХЗХ-ны 2018 оны үйл ажиллагааны тайлан, 2018 онд Хорооны хуралдаанаар баталсан 46 тогтоол, 16 хуралдааны тэмдэглэлийг зохих журмын дагуу судалгаа тайлан ба архивын товчоог бүрдүүлж, хэрэгжилтийн тайлангийн хамт ЗУХАГ, архивт хүлээлгэн өгч цахим хэлбэрт шилжүүлсэн.

Нэг. Салбарын зохицуулалтын эрх зүйн орчин, зохицуулалтын баримт бичгийг боловсронгуй болгох талаар:

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас харилцаа холбоо (цахилгаан холбоо, радио телевиз, шуудан, мэдээллийн технологийн бүх төрлийг)-ны салбарыг Монгол Улсын тогтвортой хөгжил, хүний хөгжлийг хурдасгагч, мэдлэгт суурилсан нийгэм байгуулах, эдгээрийг дэмжих хөшүүрэг гэж тодорхойлсон.



Мэдээлэл, харилцаа холбооны салбарын эрхзүйн орчинг тухай бүр шинэ нөхцөлд нийцүүлэн боловсронгуй болгох, төрөөс салбарын талаар баримтлах бодлого, зохицуулалтын стратегиуд, тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааг тодорхойлсон баримт бичгүүд, түүний хэрэгжилтийг хангуулах арга, механизмыг оновчтой зөв тодорхойлох нь нэн чухал ач холбогдолтой байдаг.

Монгол Улсын Засгийн газраас харилцаа холбооны салбар, цахим засгийг хөгжүүлэх, хууль эрх зүйн орчинг шинэчлэх, төрийн удирдлагын үр нөлөө, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, тэргүүний техник технологийн ололтыг нийгэм, эдийн засгийн бүх хүрээнд нэвтрүүлэх нь улс орны тогтвортой хөгжлийг дэмжих чухал хэрэгсэл гэж үзэж байгаа билээ.

Салбарын хууль эрх зүйн шинэчлэлийн арга хэмжээг 2019 онд хэрэгжүүлсэн ажилласан бөгөөд УИХ-аар соёрхон баталсан Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд; шинээр баталсан Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон салбарын хууль эрх зүйн шинэчлэлтийг хэрэгжүүлэхэд УИХ-ын Байнгийн хороо, ЗГХЭГ-ын ажлын хэсэгт ХХЗХ-ны удирдлага, төлөөлөл хамтран ажиллав.

Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэн 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар **Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** болон хамт өргөн мэдүүлсэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; **Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль; **Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлуулсан нь салбарын эрх зүйн шинэчлэлтийг хэрэгжүүлэхэд чухал алхам боллоо. Үүнд:

- 2001 онд батлагдсан Харилцаа холбооны тухай хуулиар харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүнийг ашиглах, хамгаалах харилцааг зохицуулж байсан бөгөөд уг хууль нь төрийн оролцоог багасгах зорилгоор хөндлөнгийн зохицуулалтын механизмыг бүрдүүлж, зах зээлийг либеральчилж өрсөлдөөнийг бий болгосон бол энэ удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр мэдээллийн технологийн талаарх зохицуулалтыг нэмж, салбарын зохицуулалтыг нарийвчлан тусгажээ. Уг хууль батлагдсанаар харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр төрийн бодлого, зорилтыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалттайгаар ханган хэрэгжүүлэх боломж бүрдэж, салбар хоорондын харилцаа холбоо, мэдээллийн технологийн бодлого, төлөвлөлтийн нэгдмэл байдлыг хангаж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн давуу талыг ашигласны үр дүн нэмэгдэн, давхар хөрөнгө оруулалт эрс буурч, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх эрх зүйн орчин бүрдэж байна.
- Радио долгионы тухай хууль 1999 онд батлагдсанаас хойш Засгийн газрын бүтэц, чиг үүргийн өөрчлөлттэй холбогдуулан тус хуульд нэмэлт, өөрчлөлт



оруулаагүй бөгөөд үүнтэй холбоотой өөрчлөлтийг тусгах, мөн Захиргааны ерөнхий хуулийг мөрдөж эхэлсэнтэй холбоотой зохицуулалтуудыг хийх, Монгол Улсын олон улсын гэрээнд тусгагдсан нэр томъёонуудыг шинэчлэн оруулах, радио долгионы хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг багасгах зэрэг эрх зүйн шинэ зохицуулалтыг тусгах шаардлага байсан. Энэхүү 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр дараах зарчмын шинжтэй зохицуулалтуудыг хуульд шинээр оруулан батлуулав. Үүнд: радио долгион хуваарилах, ашиглах, хамгаалах, өмчлөх, эзэмшихтэй холбогдсон харилцааг зохицуулахдаа радио долгионы ашиглалттай холбоотой зөвхөн техник, технологийн талаас авч үзэхээс гадна түүний хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, давтамжийн хязгаарлагдмал нөөц баялгийг үр дүнтэй хуваарилах, нийтийн хэрэглээний радио давтамжийн нэгдсэн бодлого, төлөвлөлт болон зохицуулах байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэхтэй холбоотой харилцааг бүхэлд нь зохицуулах боломж бүрдэнэ. Түүнчлэн шинэ үйлчилгээ, техник, технологийг нэвтрүүлэх үйл явц хурдсаж, эдийн засаг, нийгмийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх, радио холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийг баталгаажуулах, радио долгионы хортой нөлөөллөөс хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг хамгаалах боломжтой болсон юм.

- Шуудангийн тухай хууль 2003 онд батлагдахдаа шуудангийн салбарт хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, шуудангийн үндсэн сүлжээг дэмжихэд чиглэгдэж байсан бол энэ удаагийн өөрчлөлтөөр салбарын өрсөлдөөнийг дэмжих, үндсэн сүлжээний ашиглалтыг сайжруулах, мэдээллийн технологийн хөгжлийг дагасан шинэ бүтээгдэхүүн, технологийн давуу талуудыг шуудангийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх зэрэг өөрчлөлттэй уялдуулж эрх зүйн шинэ зохицуулалтууд хийх шаардлагатай тулгарсан. Уг хууль батлагдсанаар шуудангийн салбарыг уламжлалт үйлчилгээ бүхий өнөөгийн түвшнээс олон улсад өрсөлдөх чадвартай, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, түүний давуу талд тулгуурласан хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, найдвартай, хурдан шуурхай хүргэлт хийх шууданг Монгол Улсад бий болгон хөгжүүлэхэд оршино. Түүнчлэн шуудангийн үйлчилгээгээр дамжуулан бусад салбарт шинэ үйлчилгээ, хэрэглээг нэвтрүүлэх цахим худалдаа, илгээмжийн үйлчилгээг ашиглах боломжийг нэмэгдүүлэх, соёлын үнэт өв болох маркийн улсын фондыг хамгаалах, зөв зохистой хадгалах нөхцөл бүрдэх, өрсөлдөөний таатай орчин бүрдүүлж, жижиг дунд үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих зэрэг нийгэм, эдийн засагт ихээхэн ач холбогдолтой юм.
- Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы (2019.12.12) хуралдаанаар **“Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд”**-ийн хамт соёрхон батлуулав. Энэхүү хуулийн зорилт нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, зах зээлийн шударга өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэх, үндэсний болон нийтийн ашиг сонирхолд нийцсэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад чиглэж байна. Энэхүү хууль батлагдснаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, зах зээлийн шударга өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэх, үндэсний болон нийтийн ашиг сонирхолд нийцсэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна. Түүнчлэн үндэсний нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн зохицуулалт, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид, радио, телевизийн газрын дамжуулах үйлчилгээ эрхлэгчид,

хөтөлбөрт тавигдах ерөнхий шаардлага болон зар сурталчилгаа, архив, олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгчид тавигдах шаардлага зэрэг асуудлыг тусгажээ. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх юм.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь “Харилцаа холбооны тухай” (2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан), “Шуудангийн тухай” (2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан), “Радио долгионы тухай” (2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан), Өргөн нэвтрүүлгийн тухай (2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр баталсан) “Цахим гарын үсгийн тухай”, “Сонгуулийн тухай” болон холбогдох Монгол Улсын хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж эдгээр хуулиудад тусгайлан заасан эрх үүргүүдийг хэрэгжүүлж байна. ХХЗХ-нд дараах холбогдох хуулийг мөрдөж ажиллаж байна. Түүнчлэн дараах хууль тогтоомжийг мөрдлөгө болгон ажиллаж байна:

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай;
- Өрсөлдөөний тухай;
- Захиргааны Ерөнхий хууль;
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай;
- Зар сурталчилгааны тухай;
- Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай;
- Засгийн газрын тусгай сангийн тухай;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай;
- Шилэн дансны тухай;
- Хэрэглэгчийн эрхийн тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай;
- Төрийн хяналт шалгалтын тухай;
- Зөрчлийн тухай;
- Олон нийтийн радио , телевизийн тухай болон МУ-ын бусад хуулиуд.

Цахим мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийн төсөлд өгөх саналыг боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлсэн. Мөн хуулийн төслийг боловсруулах дэд ажлын хэсэгт ХХЗХ-ноос ажиллаж, тухай бүр санал, үндэслэл, тайлбар, мэдээлэл гаргаж хамтран ажилласан. Сонгуулийн тухай хуулийн төсөлд тус хорооны саналыг нэгтгэн хүргүүлсэн ба хуулийн төслийг боловсруулахад сонгуулийн сурталчилгаа, сонгуулийн үед тус хорооны бүрэн эрх чиг үүргийг тодорхойлох зохилгоор ХХЗХ-ны төлөөлөл дэд ажлын хэсэгт ажиллаж, тухай бүр санал, үндэслэл, тайлбар, мэдээлэл гаргаж хүргүүлсэн.

УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн үеэр радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгаанд хяналт тавьж ажиллахад шаардагдах зардлын төсвийг гаргаж, холбогдох санхүүжилтийг төсвийн хүрээний мэдэгдэлд тусгуулах хүсэлтийг Сонгуулийн ерөнхий хороонд болон УИХ-ын Байнгын хороонд хүргүүлж, хамтран ажиллав.

Засгийн газраас өргөн барьсан Зөвшөөрлийн тухай болон Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төсөл болон УИХ-ын гишүүн Бямбацогт нарын гишүүний



санаачилсан Зөвшөөрлийн тухай хуулийн төслийн зарчмын зөрүү, анхаарвал зохих заалтуудыг тодорхойлсон харьцуулсан судалгаа хийж, ХХЗХ болон ХХМТГ-ын удирдлагуудад танилцуулан саналыг тусгасан. Хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх дэд ажлын хэсэгт ХХЗХ-ны төлөөлөл тухай бүр ажиллаж, тус хорооноос тусгасан саналын талаар холбогдох үндэслэл, тайлбар, мэдээллээр хангаж хамтран ажиллав.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 167 тоот захирамжаар "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор "Үндэсний орон зайн өгөгдөл, мэдээлэл бүхий үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах" ажлын хэсэгтэй ХХЗХ-ны төлөөлөл хамтран ажиллав.

Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн 3.2.29-ийн 8 дахь заалтын хүрээнд "Өргөн нэвтрүүлгийн тухай хууль"-ийн төслийг боловсруулж, батлуулсан ба хөтөлбөрийн 3.2.35.2 дахь заалтад заасан "нийгмийн мэдээллийн сүлжээг ашиглах зохистой хэрэглээг бий болгох" арга хэмжээний хүрээнд ЦЕГ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Хүүхэд гэр бүл залуучуудын газруудтай хамтран "Эерэг бол Гоё" уриатай хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн 5.4.4.1-ын "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах" чиглэлээр Кибер Аюулгүй байдлын хуулийг ХХМТГ, МАБГ, ХХЗХ, эрх бүхий байгууллагуудын хамтарсан ажлын хэсэг төслийг боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлээд байна..

Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан Үндэсний хиймэл дагуул хөөргөх тухай ЗГХЭГ-ын даргаар ахалсан ажлын хэсэгт ХХЗХ-ны төлөөлөл оролцон ажиллаж, АНУ, Франц, ОХУ болон бусад хиймэл дагуул үйлдвэрлэгч байгууллагуудтай хамтран ажилласан бөгөөд үндэсний хиймэл дагуулын орбитын байршлыг баталгаажуулах, хамгаалах асуудлаар 2019 оны 11 сард Дэлхийн Радиогийн Их хуралд санал оруулан боловсруулан хэлэлцүүлж тогтоолоор батлуулсан болно.

Зохицуулах хороо нь Харилцаа холбоо, мэдээллийн технологийг газрын даргын 2018 оны А/116 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, "Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө (2019-2024 он)" баримт бичгийн төсөлд тус хорооноос өгөх саналыг нэгтгэн боловсруулж хүргүүлсэн. Баримт бичгийн эцсийн хувилбарт тус хорооны санал тусгагдсан талаар удирдлагад танилцуулан, нэмэлт санал, тайлбарыг хүргүүлж хамтран ажиллав.

Үйлчилгээ эрхлэгчдийг зах зээлд шударга, үр ашигтай өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор үнэ тарифын зохицуулалтанд баримтлах "Харилцаа холбооны үйлчилгээний үнэ тариф, өрсөлдөөний талаар баримтлах бодлогын чиглэл"-ийн дагуу тус хорооноос зах зээлийн чиг хандлага, технологийн хөгжилтэй уялдуулан харилцаа холбооны салбарын үнэ тариф, өрсөлдөөний чиглэлээр тулгамдаад байсан зах зээлийн зохицуулалтын баримт бичгийг шинэчлэх, үнэ



тарифыг шинээр тогтоож батлах, Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх боломжийг бүрдүүлэн ажилласан.

ХХЗХ-ноос “Тохирлын баталгаанд заавал хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт”-д оруулах радио тоног төхөөрөмжүүдийн танилцуулга, жагсаалтын төслийг боловсруулан СХЗГ, ЗГХЭГ-т тус тус хүргүүлж, Засгийн газрын 2018 оны 291 тоот тогтоолын хавсралтаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байгаа болно. Харилцаа холбооны зохицуулах хороо нь СХЗГ-аас мэдээлэл, харилцаа холбооны төхөөрөмжийн баталгаажуулалтын үйл ажиллагаа явуулах эрхийг 2014 онд зохих хууль, тогтоомжийн хүрээнд авч итгэмжлэгдсэн. Зохицуулах хорооны 2013 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Баталгаажуулалтын хяналтын журам, Чанарын гарын авлага зэрэг 14 баримт бичгийн хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны төхөөрөмжийн баталгаажуулалтын үйл ажиллагааг гүйцэтгэн хэрэгжүүлж байгаа билээ. УИХ-аас 2018 онд шинэчлэн баталсан “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулийн холбогдох заалтууд /13, 14-р зүйл/, Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах, “Харилцаа холбооны тухай” хуулийн 9.1.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийг баталгаажуулах, холбогдох техникийн нөхцөл, шаардлага, норматив баримт бичиг, журам батлах, хэрэгжилтэд хяналт тавих заалтыг хэрэгжүүлэх зорилгоор мэдээлэл харилцаа холбооны тоног төхөөрөмжийг сорилт баталгаажуулалтад хамруулах эрх зүйн зохицуулалт шинэчлэх шаардлага гарч байгаа юм. Засгийн Газрын 2018 оны 291 дүгээр тогтоолоор батлагдсан “Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт”-д нэр бүхий мэдээлэл, харилцаа холбооны төхөөрөмжид заавал баталгаажуулалт хийхээр заасан болно. Иймээс эдгээр хууль тогтоомж, ЗГ-ын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор тус хорооны РДХЗГ-аас “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”-ын төсөл, танилцуулга, тогтоолын төслийг боловсруулан хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дах заалт болон Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн хорооны 2019 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам батлах тухай” 29 дугаар тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”-ыг шинэчлэн батлав. Энэхүү журмаар мэдээлэл харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалтыг схемийн дагуу явуулах ерөнхий харилцааны зохицуулалтыг шинэчлэн баталж тогтоосон болно.

ХХЗХ-ноос БНХАУ-ын Засгийн газраас олгох хөнгөлөлттэй зээлэнд хамрагдахаар Харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын лаборатор байгуулах тооцоо судалгаа, төслийг боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлж, Монгол Улсаас зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн жагсаалтад оруулж батлуулсан бөгөөд төслийг хэрэгжүүлэх талаар ЗГХЭГ, СЯ, ГХЯ болон БНХАУ-ын ЭСЯ-тай хамтран ажиллаж байгаа болно.



Хоёр. Зохицуулалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх талаар:

- 1) Шударга өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр :
 - Монгол банкны Үндэсний төлбөрийн системийн зөвлөл (ҮТСЗ) хуралдаанд ХХЗХ-ны төлөөлөл оролцож, 2-р хуралдаанд оролцож, PKI, гар утасны дугаараар төлбөр төлөх асуудлаар санал солилцсон. Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, ХХЗХ хоорондын гурвалсан гэрээ байгуулах харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг боловсруулав.
 - Мэдээлэл, харилцаа холбооны салбарын зүй ёсны монополь болон давамгайл байдалтай аж ахуй эрхлэгчдийг шинэчлэн тогтоосон.
 - Олон улсын жишгээр дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлэх талаар холбогдох судалгааны ажлуудыг үргэлжлүүлэн хийж байна.
 - Харилцаа холбооны үйлчилгээний зах зээлд монополь болон давамгайл байдалтай үйлчилгээ эрхлэгчдийн үнэ тарифт зохицуулалт хийж байгаа тус хорооны тогтоолын хэрэгжилтийг хангуулах үүднээс зохицуулалттай үйлчилгээний жагсаалт гаргаж, үнэ тарифын хяналтыг тогтмолжуулах хүснэгт бэлтгэж байнгын хяналт тавих ажлыг хийж байна.
 - Спортын контентийн чиглэлд давамгайл байдалтай "SPS" ХХК-тай 2 удаа уулзалт зохион байгуулан цаашид холболтын үнэ тарифыг хороогоор хянуулах, тэгш өрсөлдөх боломжийг хангаж ажиллах талаар зөвлөмж өгсөн.
- 2) Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжүүдэд баталгаажуулалтын чиглэлээр ОУЦХБ-аас зөвлөх үйлчилгээ авч MNS ISO:17065 үндэсний стандартын дагуу баталгаажуулалтыг хийж байна. (тоног төхөөрөмжийн баталгаажуулалтыг 305 төхөөрөмжинд хийсэн.)
- 3) Радио давтамжийн хяналт, зохицуулалтын чиглэлээр:
 - Төлөвлөгөөт хяналт, шалгалтын хүрээнд нийт 74 телевиз, сувгийн үйл ажиллагаанд хэмжилт, шалгалт хийж, зөвлөмж мэдээлэл өгч ажилласанаас 21 тусгай зөвшөөрөл эзэмшигч /ТЗЭ/-д анхааруулга, сануулга, 4 ТЗЭ-д хугацаатай үүрэг даалгавар, 5 ТЗЭ-д тусгай зөвшөөрлийг /ТЗ/ түдгэлзүүлэх тухай улсын байцаагчийн дүгнэлт боловсруулж, хүргүүлсэн. Хугацаатай үүрэг даалгавар, түдгэлзүүлэх арга хэмжээ авсан.
 - Харилцаа холбооны улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн 2, нийт 7 сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн шалгалт хийх тухай 2019 оны А-284 тушаал, удирдамжийн дагуу 7 кабелийн сувгийн үйл ажиллагаанд шалгалт хийж, тайлан, дүгнэлт, арга хэмжээний саналыг боловсруулж танилцуулсан. Сонсгол хийх үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлэх албан тоотын төслийг боловсруулан ЗЕХ-ийн дагуу ажиллагааг зохион байгуулсан.
 - 2019 оны дүнгээр Улаанбаатар хотын 20, орон нутгийн хамрах хүрээ өргөжүүлсэн 4 телевиз, Улаанбаатар хотын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 50 сувгийн үйлчилгээ эрхлэгчдэд зөрчлийн дүнгээр сануулах албан тоотыг хүргүүлэн зөрчил дутагдлыг арилгав.



- Радио давтамж ашиглах эрхийн бичгийн хугацаа сунгуулах 118 хүсэлт, өөрчлөлт оруулах 42 хүсэлтийн ирүүлсэн баримт бичгийг судлан холбогдох дүрэм журмын дагуу радио давтамжийн хуваарилалтыг дахин хийж үнэлгээг гарган ЗУХАГ-т хүргүүлэв. Үүнд: Хугацаа сунгах – 121, Өөрчлөлт оруулах – 46, Хүчингүй болгох – 9
- Монгол Улс болон БНХАУ хоорондын хил орчмын радио давтамжийн зохицуулалтын III уулзалтыг 2019 оны 10 дугаар сард БНХАУ-ын Бээжин хотноо зохион байгуулав. Уулзалтад Монголын талыг төлөөлж Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Монгол Улсаас Бээжин хотноо суугаа Элчин сайдын яам болон үүрэн холбооны Мобиком, Юнител компаниуд, БНХАУ-ын талыг төлөөлж Мэдээлэл, технологийн аж үйлдвэрийн яамны харьяа Радио зохицуулалтын товчоо, Радио хяналтын улсын төв, Үндэсний радио давтамжийн менежментийн судалгааны байгууллага, Өвөр монгол, Гансу, Шинжъян мужийн салбар байгууллагууд болон үүрэн холбооны операторууд оролцов. Хил орчмын бүс нутаг дахь радио давтамжийн зурвасын зохицуулалтын анхны гэрээнд гарын үсэг зурсан явдал нь радио давтамжийн хилийн бүсээ баталгаажуулахад чухал алхам болсон. Ингэснээр Монгол Улс нь БНХАУ-тай хил орчмын радио давтамжийн зохицуулалтын гэрээг үзэглэсэн хоёр дахь улс болж байгаа юм. Үүнд: хил орчмын бүс нутаг дахь радио давтамжийн төлөвлөлт, хуваарилалт, бодлого зохицуулалтын талаар танилцуулж, IMT системийн радио давтамжийн ашиглалтыг үр ашигтай зохицуулах асуудлаар санал солилцов. Цаашид хийх, арга хэмжээ авах ажлын хүрээгээ тохиролцож, радио давтамжийн зохицуулалтын үйл ажиллагааг гүйцэтгэх боломжтой болов.
- Хорооны хуралдааны 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 23 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг батлан шийдвэрлэв. Энэхүү баримт бичгийг шинэчлэн баталснаар Дэлхийн Радиогийн их хурлаас баталсан “Олон улсын радио давтамжийн дүрэм”, Монгол Улсын “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-ийн дагуу Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасыг хуваарилах, холбогдох техникийн нөхцөл, шаардлагыг тогтоох, уг баримт бичгийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх, радио зурвасыг үр ашигтай ашиглах нөхцөл, хяналтын арга хэмжээг бүрдүүлэн 2019 онд тухай бүр асуудлыг шийдвэрлүүлэн хэрэгжүүлж ажиллав.
- Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газраас ирүүлсэн ОХУ-ын MC-1179, MC-1203, MC-1283 MC-1379, MC-1576, MC-2334 болон Тайландын Вант Улсын зохицуулах хорооноос ирүүлсэн THAICOM-Q2, THAICOM-LSX2R өргөн нэвтрүүлгийн хиймэл дагуулыг хүлээн зөвшөөрөх тухай хүсэлт, мөн SES байгууллагаас ирүүлсэн нисэх онгоцонд суурилуулагддаг хиймэл дагуулын өргөн зурвасын үйлчилгээний талаарх хүсэлтэд холбогдох хариуг өгч ажиллав.
- Дэлхий радиогийн их хурал /ДРИХ/-д бэлтгэх ээлжит Ази-Номхон Далайн Цахилгаан холбооны гишүүн байгууллагуудын 5 дахь удаагийн хуралд



АНДЦХБ-ын гишүүн 25 орны 470 төлөөлөгчид оролцож, ДРИХ-д хэлэлцүүлэх 25 бүлэг асуудлыг хэлэлцэн 44 асуудалд санал нэгдэж АНДЦХБ-ын нэгдсэн саналыг эцэслэн баталлаа.

4) Зохицуулалтын төсөл, арга хэмжээнүүд :

- Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Ухаалаг төхөөрөмж болон гар утсыг хайх” системийг ХЗДХЯ, Үндэсний Дата Төв, оператор компанитай хамтран нэвтрүүлэхээр ажиллаж гар утасны имей код, дугаар болон хэрэглэгчийн регистрийн дугаарын мэдээллийг Үндэсний дата төвийн тусгайлсан бүртгэлийн дагуу нөхцөл, шаардлагад нийцүүлэн бүртгэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болгоод байна.
- Шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигч идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг 38 аж ахуйн нэгжийн гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх аргачлалыг боловсронгуй болгож, гэрээг дүгнэсэн. Хорооны цахим хуудас болон сургалтаар мэдээллийг хийж, мэрэгжил арга зүйн зөвлөмж өгч ажиллав.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдэд туслах зориулсан тусгай дугааруудыг олон улсын жишигт нийцүүлэн үйлчилгээнд нэвтрүүлэх арга хэмжээг авч ажиллалаа.
 - а) Харилцаа холбооны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сонсголын бэрхшээлтэй хүн, шуурхай удирдлагын төв (цагдаа, эрүүл мэнд, онцгой байдал)-ийн тусгай дугаарт дохионы хэлний хэлмэрчийн тусламжтайгаар хандаж, үйлчилгээ авах зориулалттай “миний туслах 104” үйлчилгээг нэвтрүүлж, тус дугаарт үүрэн холбооны бүх операторын дугаараас үнэ төлбөргүй холбогдох боломжийг бүрдүүлсэн.
 - б) Хүүхдийн тухай хуульд санал хүргүүлэн тус хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон улсын жишигт нийцсэн хүүхдэд туслах утсыг ажиллуулснаар хүүхдийг цахим ба бодит орчинд халдлагаас хамгаалахад бодит хувь нэмрээ оруулж байна¹. Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бий болгоход нэн шаардлагатай уг үйлчилгээг төрөөс бодлогоор дэмжиж *"108- Хүүхдийн Тусламжийн утасны дуудлагын үйлчилээний төв"* болгон шинээр байгуулсныг НҮБ-ын харилцаа холбоо, мэдээллийн салбарын хөгжил харицсан салбар байгууллага- ОУЦХБ-аас өндрөөр үнэлж бусад улс орнуудад нэвтрүүлэх туршлага болгохыг зөвлөсөн.

Гурав. Зохицуулалтын үйл ажиллагааг нийтэд ил тод, хүртээмжтэй болгох талаар:

- 2019 оны эцсийн байдлаар, ХХЗХ-д нийт 216 гомдол, санал (бичгээр - 51, утсаар- 75, имэйлээр-15, биеэр-5, 11-11 төвөөр - 70) ирүүлсэний бүртгэлжүүлэн бүртгэлийн сан үүсгэсэн. Эдгээрээс 4 гомдол дээр зөрчлийн хэрэг үүсгэгдсэн. Шийдвэрлэлтийн шатандаа яваа 2 гомдол байна. Хугацаа хэтэрсэн гомдол байхгүй. Бусад гомдлуудыг шийдвэрлэсэн байна.
- Зохицуулалтын үйл ажиллагаанд хэрэглэгддэг зохицуулалтын нөхцөл шаардлага, дүрэм журам, радио давтамжийн хуваарилалтын талаарх эрх

¹5000 гаруй амь нас эрсдэж болохуйц эрсдэлийн үеийн дуудлага хүлээн авч үйлчилсэн.



зүйн 70 гаруй баримт бичигт дүн шинжилгээ хийж цэгцлэн үйлчлэгч болон хэрэглэгч, олон нийтэд цахим хуудсаар нээлттэй болгон ажиллаж байна.

- Салбарын суурь хуулиуд, зохицуулалтын үйл ажиллагаанд хамааралтай хууль тогтоомжинд саналаа ажлын хэсэг, албан тоотоор хүргүүлж хамтран ажиллалаа.
- ХХЗХ-ны оны ном /2018-2019/, сэтгүүлийн тусгай дугаар, танилцуулга (newsletter, banner) хэвлэн үнэ төлбөргүй түгээж хэрэглэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт байгууллагын үйл ажиллагаа, тогтоол шийдвэр, дүрэм журам, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр үзүүлэн ажиллав.
- Цахим орчны зүй бус хэрэглээ болон халдлагаас хамгаалах зорилгоор ekids.mn; cybersafety.mn цахим хуудсыг удирдан ажиллуулж байна.
- Цахим орчны гадуурхалын талаар хүүхдүүдэд ойлголт өгөх гар зураг, эссе, захидал бичлэгийн уралдааныг зохион байгуулж, нийт 11 аймаг, нийслэлийн 8 дүүргийн захидал, эссе, гар зургийн нийт 3800 гаруй бүтээл ирснийг шалгаруулан урамшуулж ажилласан.

Сургалт семинар, хөтөлбөр, арга хэмжээнүүд зохион байгуулах болон мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх талаар: Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллггааны мөрийн хөтөлбөрийн хүрээнд салбарын зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагууд болох УИХ, ЗГХЭГ, ХХМТГ, холбогдох яам, агентлагууд, ШӨХТГ, ТЕГ, ЭЦГ, МХЕГ, ОӨУБГ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажилласан. Үүнд:

- УИХ-ын Цахим бодлогын түр хорооны ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, “Хүүхдийг тэдгээрийн эрүүл мэнд, хөгжилд сөрөг нөлөө үзүүлэхүйц мэдээллээс хамгаалах тухай” хуулийн төсөлд цахим орчинд баримтлах зохицуулалтын талаарх санал өгсөн.
- УИХ-ын Байнгын хороонд хүргүүлэх Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаарх тайланд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8.2 дахь заалтын хэрэгжилтийн хүрээнд Өргөн нэвтрүүлгийн орчинд хүүхдийг зохисгүй мэдээлэл, сурталчилгаанаас хамгаалах чиглэлээр Хорооноос хийгдсэн ажлуудыг нэгтгэн, товч тайлан гаргаж, үр дүнгийн хамт тусгаж, хүргүүлэв.
- Өргөн нэвтрүүлгийн хуулийн төслийн дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ХХЗХ-ны удирдлага, төлөөлөл ажиллаж албан 5, албан бус 3 удаагийн хуралд оролцож, саналаа дэвшүүлж, хуулийн төсөлд зохих өөрчлөлтүүдийг тусгуулав. Өргөн нэвтрүүлгийн хуулийн төсөлтэй холбогдуулан ОСДҮЭ-дийн (Юнивишн, Скаймедиа, ДДэшТВ, ЭнБиСи) удирдлага, холбогдох ажилтнуудтай үйлчилгээний үнэ тариф, орлого, зардлын мэдээллийн талаар хийсэн 4 уулзалтыг зохион байгуулсан. Өргөн нэвтрүүлгийн хуулийн төслийн санал боловсруулж, хуулийн төслийн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг боловсруулж ажлын хэсэгт танилцуулж, холбогдох тайлбар, мэдээллээр хангаж ажилласан. Хуулийн төслийг УИХ-ын ТББХ-гоор, УИХ-ын анхны хэлэлцүүлгээр хэлэлцүүлэхэд оролцож, холбогдох тайлбар, мэдээллийг хийж ажиллан УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.
- Харилцаа холбооны зохицуулах хороо нь 2006 оноос эхлэн бүсчилсэн зөвлөгөөн, сургалт семинарыг жил бүр зохион байгуулдаг уламжлалтай билээ. Бүсийн зөвлөгөөний үндсэн зорилго нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хөгжлийн чиг хандлагууд, тэргүүн туршлагыг түгээх,



шинэ технологи, үйлчилгээг нутагшуулах, бодлого зохицуулалтын тулгамдсан асуудлаа хамтран хэлэлцэх, тухайн бүсийн орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн чадавхийг дээшлүүлэх, хорооноос баталсан тогтоол шийдвэр, зохицуулалтын баримт бичгийг танилцуулах, мэргэжил арга зүйн зөвлөмж үзүүлэх, орон нутгийн үйлчилгээ эрхлэгчдийн саналыг авч үйл ажиллагаандаа авч тусгахад чиглэдэг билээ. Харилцаа холбооны хөгжил-2019 зүүн бүсийн семинарыг Сүхбаатар аймагт 2019 оны 9 сард зохион байгуулж, УИХ-ын хаврын чуулганаар батлагдсан Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай хуулиудын нэмэлт өөрчлөлт, салбарын бодлого, зохицуулалтын чиг хандлага, 2019 онд хийгдэж буй зохицуулалтууд, цаашлаад ирэх онуудад хийх зохицуулалтын бодлого, чиг хандлага технологийн хөгжил дэвшил, тэднийг нэвтрүүлэхтэй холбоотой судалгаа шинжилгээний дүн болон хорооны үйл ажиллагаа, тайлан мэдээ, мэдээлэл, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шинээр батлагдсан хууль тогтоомжийг танилцуулан, хяналт шалгалтын үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн болно. Зүүн бүсийн аймгуудад харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийн дунд хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнгээр зөвлөмж шаардлага хүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, үйл ажиллагаа эрхэлдэг төр, хувийн хэвшлийн байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй харилцан санал солилцож тулгамдаж буй асуудлыг хэлэлцэн төр, хувийн хэвшил, тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт хандсан зөвлөмж гаргасан болно.

- Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Эстони Улсын Цахим-Засаглалын академитай хамтран “Дижитал Монгол улс” хэлэлцүүлгийг Гадаад хэргийн яамны зөвшилцөл танхимд 2019 оны 12 сарын 04-ны өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Монгол улсын ерөнхийлөгч, Улсын их хурал, Засгийн газрын гишүүд, төр, хувийн хэвшил болон хөрөнгө оруулагчид оролцсон бөгөөд Эстони улсын Цахим-Засаглалын академийн дэд захирал Ханнес Асток тэргүүтэй төлөөлөгчид хүрэлцэн ирж, Монгол улсын цахим хөгжлийн явцтай танилцан, “И-Эстони экосистем ба X-road архитектур”, “Бүрэн дижиталчлал хийхэд шаардлагатай бодлого, зохицуулалтын шинэчлэл”, “Зохицуулалт, хамтын ажиллагааны механизм” сэдвээр илтгэл тавьж оролцогчидтой санал бодлоо хуваалцсан ба тэргүүн туршлагаас хэрэгжүүлэхээр тохиолцов.
- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын “ICT-Expo-2019” үзэсгэлэнг “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн Экспо-2019” үзэсгэлэн, яармагийн арга хэмжээг Харилцаа холбооны зохицуулах хороо нь хамтран зохион байгуулагчаар “ДИЖИТАЛ ХӨГЖИЛД ХАМТДАА” уриан дор 13 дах удаагаа зохион хамтран байгуулж, салбарын үзэсгэлэн, яармаг болон дижитал хөгжил, цахим санхүү, контент, дижитал хэрэглэгч-эрүүл мэнд зэрэг сэдвээр форум, семинарыг зохион байгуулсан.
- Шуудангийн нэгдсэн кодыг өргөжүүлэх, кодын өргөтгөл оноох чиглэлээр Төв аймаг, Дорноговь аймгийн Сайншанд, Говьсүмбэр аймгуудад ажиллан 210 гаруй төрийн албан хаагчдыг хамруулсан сургалтыг зохион байгууллаа. Шалгалтанд нийт 5 газар хамрагдсан бөгөөд телевизийн зөвшөөрөлтэй Теч стамрт солюшн ХХК нь зөвшөөрөлгүйгээр 88,8 FM ажиллуулж байлаа. Тоцмо ХХК нь давтамжийн ТЗ хүчингүй болсон үйлчилгээний тусгай зөвшөөрөл нь хугацаа нь дууссан боловч 30 гаруй хэрэглэгчтэйгээр үйл ажиллагаа явуулж



- байсныг илрүүлж ЗБХГ-т мэдээллээ. Дорноговь аймгийн Замын-Үүд суманд шуудангийн нэгдсэн код, хаягжуулалтаар сургалтыг зохион байгуулж холбогдох тайлан гарган, мэдээг хорооны цахим хуудсанд байршуулав.
- ОУЦХБ-аас баталсан IDI index тооцох аргачлалын дагуу Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарын статистик үзүүлэлтүүдийг 21 аймаг болон бүс нутгаар гаргасан.
 - ХХЗХ-ноос санаачлан Шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн ажилтнуудыг давтан сургах, мэргэшүүлэх зорилгоор Мэдээлэл Холбооны Технологийн сургуулийн сургалтын төвд 14 хоногийн сургалтыг 2019 оны 6 дугаар сард зохион байгуулав. Сургалтыг 2007 онд батлагдсан "Шууданч" мэргэжлийн боловсрол сургалтын хөтөлбөрөөс сонгож авсан үйлчилгээний ажилтан заавал эзэмшсэн байх чадварын талаархи шинэчилсэн хөтөлбөрөөр явуулсан бөгөөд нийт 14 ажилтнууд суралцан төгсөж мэргэжлийн ур чадвар, мэдлэгээ дээшлүүлэх боломжийг бүргүүлэв.
 - Шуудангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль 2019 оны 05 дугаар сарын 30-нд батлагдсанаар шуудангийн үйлчилгээний стандартуудыг шинэчлэх ажлыг ХХЗХ-ны ШЗГ-аас хийж гүйцэтгэлээ. ХХЗХ-ны захиалгаар шуудангийн стандарт болох MNS 5381-ийн 2-13-р хэсэг, MNS 5382-ын 1-8-р хэсэг, MNS 5541-ийн 1-4-р хэсгүүдийг хүчингүй болгож, Шуудангийн үйлчилгээнд тавих шаардлага MNS6776:2019 болгон шинэчлэн боловсруулж, Шуудангийн аюулгүй байдал MNS5539:2019, Хаягийн бичвэрт тавих шаардлага MNS6775:2019 стандартыг боловсруулан Стандарт хэмжил зүйн газрын Даргын 2019 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн тушаалаар батлан хэрэгжүүлж эхэллээ.
 - ҮАБЗ-тэй хамтран “Цахим мэдээллийн аюулгүй байдал-2019” сэдэвт зөвлөгөөн, семинарт цахим орчины зохицуулалт, аюулгүй байдлын талаар илтгэл тавьж 2019 оны 12 дугаар сард хамтран зохион байгуулав.

Харилцаа холбооны давтамж ашиглах эрхийн бичиг олгох, баталгаажуулалтын эрх олгох үйл ажиллагаа:

- Харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх;
- 2019 онд, Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах; Эрхийн бичиг авахаар 202 хүсэлт ирснээс 202-ыг шийдвэрлэсэн. * Бүртгэлийн гэрчилгээ авахаар 145 хүсэлт ирснээс 142 тус тус шинээр олгосон байна. (Үлдсэн 3 хүсэлт нь материалын иж бүрдэл дутуу байсан)
- Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг, бүртгэлийн гэрчилгээ эзэмшигчид болон бусад иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлж буй тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг, бүртгэлийн гэрчилгээтэй холбоотой аливаа хүсэлт, өргөдөл, гомдолд тухай бүр хариу өгч ажилласан ба утсаар болон биечлэн ирж уулзаж буй хүмүүст шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллаж байна. Тайлант хугацаанд 705 хүсэлтийн материал үнэлгээ хийсэн байна.
- 2019 онд буюу тайлант хугацаанд баталгаажуулалтын үнэлгээний хорооны хуралдааныг 18 удаа зохион байгуулж 305 төхөөрөмжийн баталгаажуулалтын үнэлгээг танилцуулж шийдвэрлүүлэв. Тохирлын гэрчилгээ шинээр авах, сунгалт хийлгэх хүсэлтийг хүлээн авч, үнэлгээ хийж дүгнэлт гаргасан. Үүнд: шинээр – 297, сунгалт-8.



- 2019 оны 12 сарын эцсийн байдлаар хорооны хуралдааны тогтоолоор батлагдсан РД ашиглахад шинээр олгох - 16, өөрчлөлт оруулах - 8, хүчингүй болгох - 15 ТЗ-ийн мэдээллийг Зөвшөөрлийн бүртгэл, төлбөр тооцооны програмд орсон байдалд тулгалт хийв.
- 2019 оны эцсийн байдлаар, радио давтамж ашиглах нийт 189 тусгай зөвшөөрөл хүчинтэй байна. Үүнд: Дамжуулан хүргэх (Радио релей) - 10, Дамжуулан хүргэх (Сансрын хөдөлгөөнт холбоо) - 4, Интернэт - 30, Урт, дунд долгионы ФМ - 3, Хэт богино долгионы ФМ - 67, Сансрын холбоо (Хиймэл дагуулаар ТВ-ийн олон суваг дамжуулах)- 2, Телевизийн өргөн нэвтрүүлэг - 1, Тоон радио өргөн нэвтрүүлэг - 1, Тоон телевизийн олон суваг дамжуулах - 40, Үүрэн холбоо - 25, Хиймэл дагуулын холбоо - 6
- 2019 онд Хорооны Даргын 5 удаагийн даргын тушаалаар радио давтамжийн нийт 22 тусгай зөвшөөрлийн хугацаа сунгагдсан, 9 тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт орсон, 5 тусгай зөвшөөрлийн хугацааг дуусгавар болгосон.
- Контентийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг, бүртгэлийн гэрчилгээг олгож нийт 2628 тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг, бүртгэлийн гэрчилгээтэйгээр тус салбарын үйл ажиллагаа явагдаж байна.

Дөрөв. Зохицуулах хорооны хуралдаанаар баталсан тогтоол, шийдвэр, түүний хэрэгжилтийг хангуулах талаар:

ХХЗХ-ноос 2019 онд мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн салбарын зохицуулалтын чиглэлээр одоо хүчин төгөлдөр мөрдөж буй зохицуулалтын баримт бичиг болох 70 гаруй дүрэм журам, нөхцөл шаардлага, техникийн нөхцөл, давтамжийн зохицуулалт, хуваарилалтын баримт бичгийн эрх зүйн актад дүн шинжилгээ, мониторинг хийснээр Захиргааны ерөнхий хууль, хууль тогтоомжид нийцүүлэн дараах зохицуулалтын баримт бичгүүдийг ХХЗХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэв (Хавсралт-1). Үүнд:

- “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019-2024 оны үйл ажиллагааны стратеги” (2019 оны 01 тоот тогтоол);
- “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-нд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2019 оны 05 тоот тогтоол);
- “Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2019 оны 09 тоот тогтоол);
- Журам батлах тухай (Харилцаа холбооны хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн системийн техникийн нөхцөл, шаардлага тогтоох журам), 2019 оны 13 тоот тогтоол;
- “Богино зайн радио холбооны тоног төхөөрөмжинд ашиглах радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг тогтоож батлах тухай (2019 оны 14 тоот тогтоол, ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн 4389 тоот улсын бүртгэлд 2019 оны 6 дугаар сарын 05-ны өдөр бүртгүүлэн баталгаажуулав, ХЗДХЯ №4389);
- “Орон нутагт хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт”-ыг батлах тухай (2019 оны 15 тоот тогтоол);



- “Нэвтрүүлэх болон хүлээн авах антенны төхөөрөмжийг бүртгэлжүүлэх нөхцөл, шаардлага” тогтоож батлах тухай (2019 оны 15 тоот тогтоол);
- Шинэчлэн батлах тухай (Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг) (2019 оны 28 тоот тогтоол);
- “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”-ыг батлах тухай (2019 оны 29 тоот тогтоол, ХЗДХЯ №4417);
- “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай (2019 оны 35 тоот тогтоол);
- Журам шинэчлэн батлах тухай (Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам), 2019 оны 41 тоот тогтоол, ХЗДХЯ №4692;
- “Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн шаардлага, норматив”-ыг батлах тухай (2019 оны 42 тоот тогтоол, ХЗДХЯ №4693);
- “Баталгаажуулалтын үйл ажиллагааны журмуудыг шинэчлэн батлах тухай (2019 оны 43 тоот тогтоол);
- “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-нд нэмэлт оруулах тухай (2019 оны 44 тоот тогтоол);
- “Шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай (2019 оны 52 тоот тогтоол, ХЗДХЯ №4694);
- “Шуудангийн үйлчилгээ эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай (2019 оны 53 тоот тогтоол, ХЗДХЯ №4695);
- “Шуудангийн харилцан холболтын журам”-ыг шинэчлэн батлах тухай (2019 оны 54 тоот тогтоол, ХЗДХЯ №4696);
- Журам батлах тухай “Радио төхөөрөмж ажиллуулах, үйл ажиллагааг нь зогсоох, хориглох журам” (2019 оны 55 тоот тогтоол, ХЗДХЯ №4697);
- “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлогын төлөвлөгөө, зардал, 2021-2022 оны төсвийн төсөөлөл”-ийг батлах тухай (2019 оны 60 тоот тогтоол) зэрэг болно.

Хорооны 2019 оны ээлжит 8 дугаар хуралдаанаар “ХХЗХ-ны 2019 оны эхний хагас жилд баталсан тогтоол шийдвэр, хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн тайлан”, холбогдох танилцуулгыг хэлэлцүүлсэн болно.

Хорооны хуралдаанаар салбарын зохицуулалтын баримт бичиг, дүрэм журам, нөхцөл шаардлагын шинэчлэлтийг хийх явцад одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа зохицуулалтын баримт бичгийн 30 гаруйг багцлан шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Тайлангийн хугацаанд ХХЗХ-ны 2019 оны ээлжит 12, ээлжит бус 2 удаагийн хуралдаанаас баталсан тогтоол, шийдвэрийн жагсаалтыг (хавсралт-1) нэгтгэн үзүүлэв. (2019 оны тогтоол, шийдвэрийг нэгтгэн үзүүлбэл):

- Зохицуулах хорооны үйл ажиллагаандаа хүчин төгөлдөр мөрдөж байгаа эрхзүйн хэм хэмжээний акт буюу зохицуулалтын чиглэл, дүрэм журам, нөхцөл шаардлага, давтамжийн хуваарилалт ба төлөвлөлтийн баримт бичиг-73;
- Захиргааны ерөнхий хууль, УИХ-аас 2019 оны 5 дугаар сард Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай хуульд тус тус



- оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлж, шинэчилэх, нэмэлт өөрчлөлт оруулан шинээр тогтоож баталсан 19;
- Зохицуулалтын баримт бичиг, давтамжийн хуваарилалт, нөхцөл шаардлага ХЗДХЯ-нд нийтээр даган мөрдөх хэм хэмжээнд хянуулан бүртгүүлэхээр албан тоотоор хүргүүлсэн ба ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн санд 3 баримт бичгийг бүртгүүлсэн болно.
 - Шинээр болон шинэчлэн, нэгтгэн боловсруулж батлуулсан (техникийн нөхцөл шаардлага, давтамжийн хуваарилалт, баталгаажуулалт, зөвлөмж, үнэ тариф тогтоох)-17;
 - Тогтоолын хавсралт болон тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулсан-2;
 - Захиргааны ерөнхий хууль, УИХ-аас 2019 оны 5 сард Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай хуульд тус тус оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу шинэчлэн баталсан болон үйлчлэх хугацаа хугацаа дууссан, хүчингүй болгосон-32 баримт бичиг зэрэг болно.

Зохицуулах хорооны 2019 оны хуралдаанаар баталж, ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн санд хянуулан бүртгүүлсэн 3 баримт бичгийг Захиргааны ерөнхий хуулийн дагуу эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (www.legalinfo.mn), хорооны цахим хуудас (www.crc.gov.mn)-д тус тус байршуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны ээлжит 12, ээлжит бус 2 удаагийн хорооны хуралдаанаар тусгай зөвшөөрлийн үйлчилгээний талаар баталсан нийтдээ 38 тогтоолын хавсралтаар (Хавсралт-2, 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар):

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 130 иргэн, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл шинээр олгосон;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2 дах хэсэг, 10.3.1, 10.3.3 дах заалтыг тус тус үндэслэн 25 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн хамрах хүрээ болон радио давтамжийн зурваст нэмэлт, өөрчлөлт оруулсан;
- Ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Харилцаа холбооны хяналтын улсын байцаагчийн 2019 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн 57-07-002/14, 57-07-002/15, 57-07-002/17, 57-07-002/18 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг 2 сараар, 4 хуулийн этгээдийн 4 тусгай зөвшөөрлийг 3 сараар, 4 хуулийн этгээдийн 4 сараар; Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа



эрхлэх зөвшөөрлийн журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.1.3 дэх заалтыг тус тус үндэслэн тусгай зөвшөөрлийн холбогдох журам, нөхцөл шаардлагыг биелүүлээгүй, өр төлбөрийн үлдэгдлийг заасан хугацаанд барагдуулаагүй нэр бүхий 73 иргэн, хуулийн этгээдийн 98 тусгай зөвшөөрлийг 1-4 сарын хугацаагаар тус тус түдгэлзүүлсэн;

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дах заалт, 13 дугаар зүйлийн 13.3 дах хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалтыг тус тус үндэслэн 6 иргэн, хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг сэргээсэн;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан "Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам"-ын 12.1.1 дах заалт болон тухайн компаниудаас ирүүлсэн хүсэлт; Харилцаа холбооны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 25 дугаар зүйлийн 25.2.10 дах заалт, Радио долгионы тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дах заалт, 19 дүгээр зүйлийн 19.2.3 дах заалт, Шуудангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.5 дах заалт, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дах заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам"-ын 12.1.4 дэх заалт болон тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулсан зөвшөөрлийн гэрээний холбогдох зүйл, заалтыг тус тус үндэслэн 135 иргэн, хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон асуудлыг тус тус хэлэлцэн шийдвэрлэв.

ХХЗХ-ны хуралдааны тогтоол, тэмдэглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах, батлагдсан зохицуулалтын чиглэл, дүрэм журам, нөхцөл шаардлагын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд ЗГХЭГ, холбогдох яам-ХЗДХЯ, ХХМТГ, ТӨБЗГ, ҮДТ, ШӨХТГ, ОӨУБЕГ, ХТГ, ЦЕГ зэрэг байгууллага, дүүрэг, татварын алба, мэргэжлийн хяналтын газар, ААН, тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэн, хуулийн этгээд нарт 1400 гаруй албан тоотоор тус тус албажуулан хүргүүлэх арга хэмжээг авч ажиллав. Түүнчлэн Захиргааны хэргийн шүүх, ТЦГ, МАБГ, Оюу толгой ХХК, МХС ХХК, БНҮҮС, МЦХ ХК, Мобиком ХХК, Скайтел ХХК, Юнител ХХК, Жи-Мобайл ХХК, Сансар ТВ, Рэйлком төв, ТЕГ зэрэг тусгай зөвшөөрөл эзэмшигч, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу тогтоолыг хавсралтын хамт албажуулан албан тоотоор хүргүүлж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

ХХЗХ-ны Дарга, Хорооны хуралдаанаас өгсөн үүрэг даалгавар, удирдамж чиглэл, хуралдааны дэгийн хүрээнд 2019 онд нийтдээ 12 удаа ээлжит, 2 удаа ээлжит бус хуралдааныг зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөт болон цаг үеийн нийтдээ 120 гаруй асуудлуудыг хэлэлцүүлж, хорооны хуралдааны 62 тогтоол, 20 удаагийн хуралдааны тэмдэглэл гарган шийдвэрлэсэн бөгөөд хорооны ээлжит хуралдаан тус бүрээр тоймлон үзүүлбэл:

1. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны ээлжит 01 дүгээр хуралдааныг 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан ба уг хуралдаанаар "Харилцаа холбооны зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги: 2019-2024 он" баримт бичгийн төсөл, тогтоол батлах тухай; ХХЗХ-ны



2018 оны төлөвлөгөөний гүйцэтгэл, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсвийн талаар танилцуулга (Бүтцийн нэгж: ЗУХАГ, РДЗХГ, ШЗГ, ЗБХГ, ЗЗҮТҮСГ); Захиргааны ерөнхий хуульд хорооны тогтоолыг нийцүүлэх тухай (Хорооны 2015 оны 65 тоот тогтоол); ОСДҮЭ-ийн нөхцөл шаардлагын хэрэгжилт болон өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрийн 2017-2018 оны хяналт, мониторингийн дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналын тухай (Хорооны 2018 оны 19 тоот тогтоолын хэрэгжилт); “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-ын хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын талаар танилцуулга; ХХЗХ-ны 2018 оны эд хөрөнгийн тооллогын дүн, зарим эд хөрөнгө актлах тухай; “Тусгай зөвшөөрөл олгох”, “Тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” боловсруулсан танилцуулга, санал дүгнэлт, тогтоолын төсөл, бусад (“Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-нд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай) нийт 8 асуудлыг хэлэлцэн тогтоол шийдвэр гаргав. Тус хуралдаан нь дээрх хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 5 тогтоолыг батлан шийдвэрлэж, хорооны хуралдааны 4 тэмдэглэлээр хугацаатай үүрэг, даалгавар холбогдох газар, хэлтэст үүрэг болголоо.

- Энэхүү хуралдаанд Харилцаа холбооны зохицуулах хорооны Даргын 2018 оны А/21 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс (ажлын хэсгийн ахлагч: Дэд дарга Д.Сэрээдорж) “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019-2024 оны үйл ажиллагааны стратеги” баримт бичгийн төсөл, танилцуулга, тогтоолын төслийг хэлэлцээд, тус хорооны Дүрмийн 2.1.2 дугаар заалтыг үндэслэн 2019 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 01 тоот тогтоолын хавсралтаар “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019-2024 оны үйл ажиллагааны стратеги”-ийг баталсан болно. Уг баримт бичгийн үндсэн зорилтыг тодорхойлохдоо Монгол хүн бүрийг орчин үеийн харилцаа холбооны дэвшилтэт үйлчилгээгээр хангах, дижитал эдийн засаг, “Мэдээлэлжсэн нийгэм”-ийн суурь үндсийг бүрдүүлэх, хөгжүүлэхэд зохицуулалтын дэмжлэг үзүүлэх замаар харилцаа холбоо, мэдээллийн технологийн ололтыг нийгэм, эдийн засгийн бүх салбар, хүн бүрийн өдөр тутмын хэрэглээ, хэрэгцээ шаардлага болгохоор заасан байна. Энэ хүрээнд тоон ялгааг бууруулж харилцаа холбооны дэвшилтэт үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх; хэрэглэгчийн эрх ашиг, нийтийн ашиг сонирхлын хамгаалах, гамшгийн үед нийтийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх; инновацийг дэмжиж, өрсөлдөөнийг төгөлдөршүүлэх замаар технологийн нэгдэн нийлэлтийг үр өгөөжийг нэмэгдүүлэх, тоон шилжилтийг хурдасгах; ХХЗХ-ны чадавхийг сайжруулах зэрэг 4 гол зорилтыг дэвшүүлж, холбогдох зорилго арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ. Баримт бичгийн тэргүүлэх стратеги, холбогдох зорилтуудыг жил бүрийн Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээ, бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус тус тусган хэрэгжилтийг зохион байгуулах, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны даргад даалгав.
- Хорооны 2018 оны ээлжит 11 дүгээр хуралдаанаас өгсөн удирдамж, чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар, Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газар, Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газар, Шуудангийн зохицуулалтын газар, Зах зээл, үнэ тарифын үнэлгээ, судалгааны газраас тус тус хорооны хуралдаанд танилцуулсан “ХХЗХ-ны 2018 оны төлөвлөгөөний гүйцэтгэл, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсвийн талаар танилцуулга”-ыг хэлэлцээд, хуралдааны үеэр хорооны дарга, гишүүдээс гаргасан санал зөвлөмж, удирдамжийг үндэслэн холбогдох чиглэлээр цаашид анхаарч ажиллах арга хэмжээ, 2019 оны хорооны ээлжит хуралдаанд үе шаттай танилцуулах, хэлэлцүүлэх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Хорооны

- Зохицуулах хорооны 2015 оны 15 тоот тогтоолоор батлагдсан “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдсэн өргөн нэвтрүүлгийн телевиз, кабелийн сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрийн байнгын хяналт, мониторингийн 2017-2018 оны дүн, зар сурталчилгааны хэтрэлтийн зөрчлийн танилцуулга, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал дүгнэлт, нэр бүхий 10 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай саналыг хуралдаанаар хэлэлцээд, тус хуралдааны 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар “Хяналт, шалгалтын үр дүн, санал дүгнэлтийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” хуралдааны тэмдэглэлээр үүрэг, даалгавар чиглэлийг хариуцсан газар, хэлтэст өглөө. Уг тэмдэглэлд, дээрх асуудлаар эрх ашиг нь хөндөгдөж байгаа эдгээр ААН, хуулийн этгээдийн удирдлага, эрх бүхий албан тушаалтантай Хорооны удирдлага, тус хорооны холбогдох газрын дарга, гэрээ эрх зүйн мэргэжилтэн, хуульчийг байлцуулан уулзалт хийх, зар сурталчилгааны хэтрэлтийн зөрчлийг арилгах үүрэг өгөх, заасан хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай тогтоолын төслийг хорооны хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэх талаар мэдэгдэх; уулзалтын протокол хөтлөн баталгаажуулж ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газарт, заасан хугацаанд хамаарах зар сурталчилгааны хэтрэлтийн зөрчлийн дүнг нэгтгэх, зөрчлийг арилгаагүй нэр бүхий хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай тогтоолын төслийг Хорооны 2019 оны ээлжит хуралдаанд тухай бүр танилцуулах, хэлэлцүүлэхийг Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газарт тус тус үүрэг болгов. Тус хорооны 2018 оны 19 дүгээр тогтоолоор “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-ын 7 дугаар зүйлийн 7.27-д оруулсан нэмэлт заалтын хэрэгжилт, 2018 оны 6 дугаар сараас 12 дугаар сард гүйцэтгэсэн хяналт мониторингийн дүн, зар сурталчилгааны хэтрэлтийн өсөлт бууралт, телевиз, кабелийн сувгийн зар сурталчилгааны хэтрэлтийн ялгаатай байдлын талаарх танилцуулга, хуралдааны тэмдэглэлийн төслийг хэлэлцэв. Тус хуралдаанаас хорооны 2018 оны 19 дүгээр тогтоолоор дээрх нөхцөл шаардлагын 7.27-д оруулсан нэмэлтийн хугацаа нь уг тогтоолын 2 дугаар заалтаар 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тул цаашид үргэлжлүүлэх шаардлагагүй гэж шийдвэрлэв.
- Зохицуулах хорооны даргын 2018 оны А/111 тоот тушаалаар хийсэн шалгалтын дүн, шалгалтаар илэрсэн зөрчилд хүргүүлсэн хугацаатай үүрэг даалгаврын биелэлт, нөхцөл шаардлагын хэрэгжилт, авах арга хэмжээний саналын тухай танилцуулга, хуралдааны тэмдэглэлийн төслийг тус хуралдаанаар хэлэлцээд, хорооны хуралдаанаас шийдвэрлэсний дагуу уг асуудлаар 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 03 тоот хуралдааны тэмдэглэлийг гаргав. Энэхүү тэмдэглэлээр, ДДэш ТВ ХХК-ийн сүлжээгээр дамжуулагдаж байгаа нэр бүхий 9 кино болон сувгууд; Юнивишн ХХК-ийн сүлжээгээр дамжуулагдаж байгаа 2 сувгууд нь тусгай зөвшөөрөлгүйгээр харилцаа холбооны сүлжээнд холболт хийж, харилцаа холбооны сүлжээ ашиглан үйлчилгээ эрхэлсэн талаар асуудалд Зөрчлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.8, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 1.8.6.10, 2.3 дугаар зүйлийн 2.3.1.1, 2.3.1.3-д тус тус заасны дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, тэмдэглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Хорооны удирдлагад үүрэг болгов.
- Захиргаа удирдлага, хамтын ажиллагааны газар болон Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газар нь 2015 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Сонирхогчийн радио станц ашиглах эрхийн бичиг олгох журам”-ыг Захиргааны



ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулсан. Уг журмыг Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 31 дүгээр тогтоолоор баталсан “Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага”-д нэмэлтээр журмын радио станцын техникийн шаардлагыг агуулсан хэсгийг хавсралт-8 болгон нэмэх буюу “Сонирхогчийн радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага” хэлбэрээр нэмэлтээр оруулах, үлдсэн эрхийн бичиг олгох холбогдох хэсгийг 2015 оны 38 дүгээр тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 3.4, 3.5, 5.12 дах заалтуудад нэмэлтээр тус тус оруулан шийдвэрлэх тухай танилцуулга, тогтоолын төслийг 2019 оны ээлжит 1 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэв. Хуралдаанаас 2015 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Сонирхогчийн радио станц ашиглах эрхийн бичиг олгох журам”-ыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэхдээ Захиргааны ерөнхий хуулийн дагуу байгууллагын цахим хуудаст байршуулан олон нийтийн саналыг авч тусган Хорооны дараагийн ээлжит хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзэв.

- Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны даргын 2018 оны А/244 тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого явуулах журмын дагуу тус хорооны эд хөрөнгийн үзлэг, тооллогыг хийх ажлын хэсэг байгуулж, 2018 оны үндсэн хөрөнгийн тооллогыг зохион байгуулсан. Ажлын хэсгээс шинэ үндсэн хөрөнгийг коджуулж бүртгэн эд хариуцагчийн бүртгэлийг шинэчлэн бүртгэлжүүлэх, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс болон үндсэн хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалттай танилцаж тооллого хийн эд хариуцагчидтай хүлээлцэх, хөрөнгийн бүртгэлийн өөрчлөлт, хөрөнгийн дахин үнэлгээ, актлах хөрөнгийн жагсаалт гаргасан болно. Тус ажлын хэсгээс гүйцэтгэсэн ажлын тайлан, актлах хөрөнгийн танилцуулга, “Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасч, актлах тухай” хуралдааны тогтоолын төслийг хавсралт жагсаалтын хамт боловсруулж, хорооны 2019 оны ээлжит 01 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлсэн. Тус хуралдаанаас Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, байгууллагын 2018 оны жилийн эцсийн эд хөрөнгийг тоолсон ажлын хэсгийн санал, дүгнэлтийг тус тус үндэслэн “Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасч, актлах тухай” 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 тоот тогтоолыг 3 хавсралтын хамт батлан шийдвэрлэв. Тогтоолын хавсралтаар баталсан жагсаалтад заасан машин; тоног төхөөрөмжүүд, тавилга, эд хогшил, програм хангамжийг тус тус үндсэн хөрөнгөөс хасч актлах, устгах саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлэхээр тогтов.
- Хорооны 2019 оны ээлжит 01 дүгээр хуралдаанаар баталсан 2019 оны 03, 04 тоот “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” 2 тогтоолын хавсралтаар:
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 14 ААН, хуулийн этгээдэд 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 тоот тогтоолын хавсралтаар 8 тусгай зөвшөөрөл шинээр олгосон;
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт



үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам"-ын 12.1.1 дах заалтыг тус тус үндэслэн 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 тоот тогтоолоор 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэсэн.

- Хорооны 2019 оны ээлжит 01 дүгээр хуралдаанд Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газраас “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-нд нэмэлт өөрчлөлт оруулах тухай танилцуулга, тогтоолын төслийг боловсруулан хэлэлцүүлсэн. Тус хуралдаанаар уг асуудлыг хэлэлцээд, Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3-т заасан бүрэн эрхийн дагуу Дэд бүтцийн сайдын 2003 оны 216 дугаар тушаалаар батлагдсан “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох журам”, Засгийн газрын 2016 оны 268 дугаар тогтоолоор батлагдсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм”-ийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 57 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-ний 3 дугаар зүйлд оруулсан нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05 тоот тогтоолын хавсралтаар батлав. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Харилцаа холбооны зохицуулах хорооны 2008 оны 15 дугаар тогтоол, 2012 оны 31 дүгээр тогтоол, 2015 оны 47 дугаар тогтоол, 66 дугаар тогтоол, 70 дугаар тогтоолын хавсралтын 1 дүгээр хэсгийг тус тус хүчингүй болгов. Хуралдаанаар баталсан 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05 тоот тогтоолыг хавсралтын хамтаар Захиргааны ерөнхий хуулийн дагуу Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн санд бүртгүүлэхээр ХЗДХЯ-нд хүргүүлээд байгаа болно.
 - Тус хорооны хуралдаанаар “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-ын хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын талаар танилцуулга, хуралдааны тэмдэглэлийн төслийг хэлэлцлээ. Хэлэлцсэн асуудлаар 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн “Өргөн нэвтрүүлгийн нөхцөл, шаардлагын талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 04 дүгээр хуралдааны тэмдэглэлийг гаргахаар тогтож, “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-д тусгай зөвшөөрлийн ангилал, хамрах хүрээ, үндсэн багц, төлбөртэй суваг, гадаад суваг, радио өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах танилцуулга, тогтоолын төслийн санал, баримт бичгийн төслийг боловсруулах, эрх ашиг нь хөндөгдөж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, байгууллагын цахим хуудсаар саналыг авч тусгах, ажлын тайлан үр дүнг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан хорооны хуралдаанд хэлэлцүүлэхийг Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газар, Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газарт тус тус үүрэг болгов.
2. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны ээлжит 2 дугаар хуралдаан 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдөр болж, тус хуралдаанаар “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны 2018 оны жилийн тайлан, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тухай”; Тусгай зөвшөөрлийн гэрээний хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний саналын тухай; “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулах саналын талаар танилцуулга (Хорооны хуралдааны 2019 оны 4 дүгээр тэмдэглэл); “Харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн системийн техникийн нөхцөл, шаардлага тогтоох журам” батлах тухай; Хэрэглэгчийн болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн сэтгэл ханамжийн судалгааны талаар танилцуулга; ХХЗХ-д 2018 онд ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтийн тухай танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай; Бусад асуудал (БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар хяналтыг сайжруулах” төслийн



танилцуулга; Монгол Улсад үүрэн холбооны радио давтамжийн ашиглалтын байдал, нөөц боломжийн тухай танилцуулга) зэрэг нийт 10 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Уг хуралдаан нь дээрх хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 3 тогтоолыг батлан шийдвэрлэж, хорооны хуралдааны 2 тэмдэглэлээр хугацаатай үүрэг, даалгавар холбогдох газар, хэлтэст үүрэг болгов.

- Зохицуулах хорооны 2019 оны ээлжит 2 дугаар хуралдаанаар “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны 2018 оны жилийн тайлан, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тухай” танилцуулга, хэрэгжилтийн тайлан, хорооны хуралдааны тэмдэглэлийн төслийг Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга /Т.Наранмандах/-аас нэгтгэн боловсруулж хэлэлцүүлсэн бөгөөд хуралдааны үеэр хорооны дарга, гишүүдийн зүгээс 2018 онд зохион байгуулсан хорооны 11 удаагийн ээлжит хуралдааны 46 тогтоол шийдвэр, 16 удаагийн хуралдааны тэмдэглэлийг тус тус батлан шийдвэрлэж, тогтоол болон тэмдэглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан, тогтоол шийдвэр, хуралдааны тэмдэглэлээр өгсөн чиглэл, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангалттай гэж дүгнэв. Тус хуралдаанаас “Хорооны хуралдааны 2018 оны жилийн эцсийн тайлан, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тухай” 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн хорооны хуралдааны 05 дугаар тэмдэглэлийг гаргаж, цаашид ажиллах удирдамж чиглэлийг Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга /Т.Наранмандах/, холбогдох газрын дарга нарт өглөө. Энэхүү тэмдэглэлд, хэрэгжилтийн хугацаа нь болоогүй байгаа 2018 оны хуралдааны 3 тэмдэглэлийн хэрэгжилтийг хангуулах, шийдвэрлэх талаар санал боловсруулж, 2019 оны 1 дүгээр улиралд багтаан хорооны хуралдаанд хэлэлцүүлэхийг Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга; Хорооны тогтоол шийдвэр, зохицуулалтын баримт бичгийг Захиргааны ерөнхий хууль болон холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэх арга хэмжээг (шинэчлэн батлах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох) эрчимжүүлэх; ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн санд бүртгүүлэх, тус яамнаас ирүүлсэн дүгнэлтийг хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах арга хэмжээг тухай бүр шуурхай авч ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/, Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга /Т.Наранмандах/-д тус тус үүрэг болгохоор тогтов. Түүнчлэн хорооны гишүүдийг шаардлагатай мэдээлэл зөвлөмжөөр хангах, хуралдааны үеэр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, гадаад дотоод албан томилолтоор ажиллах, тайлагнахад хамтран ажиллах, хорооноос 2019 онд зохион байгуулах салбарын болон бүсийн сургалт семинар, хэлэлцүүлэг, хамт олны арга хэмжээнд оролцуулах, дэмжлэг үзүүлэх; хорооны 2019 оны тогтоол, хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийн тайланг жилийн эцсээр нэгтгэн хорооны хуралдаанд танилцуулан холбогдох удирдамж, чиглэл авч ажиллахыг Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга /Т.Наранмандах/-д даалгав.
- Тус хорооны Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газраас “Тусгай зөвшөөрлийн гэрээний хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний саналын тухай” танилцуулга, тогтоолын төслийг боловсруулан танилцуулав. Харилцаа холбооны тухай хуулийн 15.1.3 (Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл авсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа явуулж эхлээгүй тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно) заалт болон “Харилцаа холбооны салбар үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам-ын 6.4, Харилцаа холбооны тухай хуулийн 15.1.1 дэх заалтын дагуу нэр бүхий хуулийн этгээд, иргэний тусгай зөвшөөрлийг хүчингүй олгох, дуусгавар болгох тухай санал, дүгнэлтийг хэлэлцээд, тус хорооны хуралдааны “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” тогтоолд хүчингүй болгох хуулийн этгээд нарыг саналыг оруулан батлах; тусгай зөвшөөрлийг дуусгавар болгох үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу шат дараалсан арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй гэж тогтов.



- Хорооны хуралдааны 2019 оны 1 дүгээр тэмдэглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хэрэглэгчийн болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн сэтгэл ханамжийн судалгааны талаар танилцуулга”-ыг хэлэлцээд, энэхүү судалгааны ажлын дэлгэрэнгүй тайлан, дүгнэлтийг ЗГХЭГ, ХХМТГ-т тус тус тус хүргүүлэх, хуулийн төслүүд хэлэлцэж байгаатай холбогдуулан мэдээлэл байдлаар түгээх, хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах нь зүйтэй гэж үзэв. Түүнчлэн “ХХЗХ-д 2018 онд ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтийн тухай танилцуулга”-ыг хуралдаанд хэлэлцүүлж, цаашид анхаарч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлийг холбогдох газар, хэлтэст үүрэг болгов.
- Хорооны хуралдааны 2019 оны 4 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор боловсруулсан “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-д (Зохицуулах хорооны 2015 оны 15 тоот тогтоолоор батлагдсан) нэмэлт, өөрчлөлт оруулах саналын талаар танилцуулгыг 2019 оны ээлжит 02 дугаар хуралдаанаар авч хэлэлцсэн. Энэхүү асуудлаар хорооны хуралдааны 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ тухай” 07 дугаар тэмдэглэлийг гаргахаар шийдвэрлэж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслөөр эрх ашиг нь хөндөгдөж буй үйлчилгээ эрхлэгч, хуулийн этгээд, оролцогч талуудтай (өргөн нэвтрүүлэг, суваг, ОСДҮЭ зэрэг үйлчилгээ эрхлэгч) цуврал уулзалтууд зохион байгуулах, баримт бичгийн төслийг байгууллагын цахим хуудаст 1 сарын хугацаагаар байршуулах, тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэдээс ирүүлсэн санал, зөвлөмжийг тусгах, баримт бичгийн төслийг эцэслэн боловсруулж, Хорооны ээлжит хуралдаанд хэлэлцүүлэхийг Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газар /С.Долгорсүрэн/-т үүрэг болгов.
- Хуралдаанаар ажлын хэсгээс хамтран боловсруулсан “Харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн системийн техникийн нөхцөл, шаардлага тогтоох журам” батлах тухай танилцуулга, тогтоолын төсөл, журмын төслийг авч хэлэлцээд, журмын төслийн талаар хуралдааны үеэр хорооны гишүүдээс гарсан санал зөвлөмжийг үндэслэн энэ чиглэлээр хөгжүүлсэн програм хангамжийг хэрэглэгчид зүгшрүүлэх, хэрэглэх арга зүйн зөвлөмж боловсруулах, олон нийтэд сурталчилах; журмын төслийг хууль тогтоомжид нийцүүлэх талаар нарийвчлан судлах, ХЗДХЯ, УБЕГ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний зөвлөл, ЦЕГ зэрэг холбогдох байгууллагаас албан тоотоор санал авч боловсруулан Хорооны хуралдаанд дахин хэлэлцүүлэхийг ажлын хэсэгт даалгав.
- Тус хуралдаанаар хэлэлцсэн бусад асуудлын хүрээнд БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа “Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар хяналтыг сайжруулах” төслийн товч танилцуулга; “Монгол Улсад үүрэн холбооны радио давтамжийн ашиглалтын байдал, нөөц боломжийн тухай” асуудлыг тус тус хуралдаанд танилцуулан хорооны гишүүдэд холбогдох мэдээлэл хийсэн болно.
- Тус хорооны хуралдаанаар “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, дүгнэлт болон тогтоолын төслийг авч хэлэлцэв. Энэхүү хэлэлцсэн асуудлаар 3 тогтоолыг батлан шийдвэрлэв:
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх



зөвшөөрлийн журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 14 ААН, хуулийн этгээдэд 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 06 тоот тогтоолын хавсралтаар 8 тусгай зөвшөөрөл шинээр олгосон;

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан "Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам"-ын 10 дугаар зүйлийн 10.2 дах хэсэг, 10.3.1, 10.3.3 дах заалтыг тус тус үндэслэн 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 07 тоот тогтоолын хавсралтаар 6 хуулийн этгээдийн 6 тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан "Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам"-ын 12.1.1 дах заалтыг тус тус үндэслэн 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 08 тоот тогтоолоор 9 хуулийн этгээдийн 10 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэсэн болно.

3. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны ээлжит 3 дугаар хуралдааныг 2019 оны 3 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан. Энэхүү хуралдаанаар Захиргааны ерөнхий хуульд хорооны тогтоолыг нийцүүлэх тухай (Хорооны 2015 оны 65 тоот тогтоол: Сонирхогчийн радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага); Монгол Шуудан ХК-ийн дотоодын үйлчилгээний үнэ тарифыг тогтоох ажлын явцын танилцуулга (Хорооны хуралдааны 2018 оны 12 дугаар тэмдэглэл); Шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийн гэрээний биелэлтийн талаар танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай; Бусад асуудал ("Монгол Телевиз ХХК-ийн гомдлын тухай" танилцуулга, Хорооны ажлын албаны даргын урамшууллын хэмжээг тогтоох тухай) зэрэг 6 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн болно. Тус хуралдаан нь хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 4 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 1 тэмдэглэлээр хугацаатай үүрэг, даалгавар холбогдох газар, хэлтэст үүрэг болголоо.

- Хорооны 2019 оны ээлжит 01 дүгээр хуралдаанаар 2015 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Сонирхогчийн радио станц ашиглах эрхийн бичиг олгох журам"-ыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэхдээ байгууллагын цахим хуудаст 1 сар байршуулан олон нийтийн саналыг авч боловсруулж, хорооны хуралдаанд дахин хэлэлцүүлэх талаар үүрэг, чиглэлийг өгсөн юм. Уг асуудлыг 2019 оны ээлжит 3 дугаар хуралдаанд Захиргаа удирдлага, хамтын ажиллагааны газар болон Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газраас шинэчилсэн танилцуулга, тогтоолын төсөл, хавсралт баримт бичгийн төслийг боловсруулан хэлэлцүүлэв. Энэхүү асуудлыг авч хэлэлцээд, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дах заалт, 9.1.10 дах заалт, Радио долгионы тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн хорооны 2019 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн "Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлагад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 09 тоот тогтоолыг баталсан. Тогтоолын хавсралтаар Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 31 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага",



- Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-д холбогдох нэмэлт өөрчлөлт оруулан шийдвэрлэсэн. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2004 оны 22 дугаар тогтоол, 2011 оны 56 дугаар тогтоол, 2015 оны 65 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгов.
- Тус хуралдаанд Монгол Шуудан ХК-ийн дотоодын үйлчилгээний үнэ тарифыг тогтоох ажлын явцын танилцуулга (Хорооны хуралдааны 2018 оны 12 дугаар тэмдэглэл); Шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийн гэрээний биелэлтийн талаар танилцуулгыг хэлэлцээд, танилцуулгатай холбоотой асуудлаар холбогдох газар хэлтэст үүрэг, чиглэл өгсөн болно.
 - Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8 дах заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн “Хорооны ажлын албаны даргын урамшууллын хэмжээг тогтоох тухай” хорооны хуралдааны 2019 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 12 дугаар тогтоолыг батлав. Тус хуралдаанд ЗУХАГ-аас “Монгол Телевиз ХХК-ийн гомдлын тухай” танилцуулгыг хийж, хорооны гишүүдэд холбогдох мэдээллийг өгөв.
 - Тус хорооны хуралдаанаар “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, санал дүгнэлт болон тогтоолын төслийг авч хэлэлцэв. Энэхүү хэлэлцсэн асуудлаар 2 тогтоолыг батлан шийдвэрлэсэн:
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 14 ААН, хуулийн этгээдэд 2019 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 10 тоот тогтоолын хавсралтаар 6 тусгай зөвшөөрөл шинээр олгосон;
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2 дах хэсэг, 10.3.1, 10.3.3 дах заалтыг тус тус үндэслэн 2019 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 11 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан;
4. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны ээлжит 4 дүгээр хуралдааныг 2019 оны 4 дүгээр сарын 29-ны өдөр зохион байгуулав. Уг хуралдаанаар “Харилцаа холбооны хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн системийн техникийн нөхцөл, шаардлага тогтоох журам”-ыг батлах тухай; “Харилцаа холбооны сүлжээний бүртгэл, мэдээллийн систем”-ийг бүрдүүлэх ажлын танилцуулга; Телевизийн мониторингийн ажлын 2018 оны үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналын талаар танилцуулга; “Мэдээлэл, харилцаа холбооны салбарын 2018 оны жилийн эцсийн статистик үзүүлэлт”-ийн танилцуулга; “Харилцаа холбооны богино зайн радио холбооны тоног төхөөрөмжийн радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг тогтоож батлах тухай (Интернет протокол ашиглан



өгөгдөл дамжуулах тоног төхөөрөмжүүдийн IoT радио давтамжийн зурвасын хуваариалалт, техникийн нөхцөл шаардлага); “Орон нутагт хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваариалалт”-ыг батлах тухай; “Улаанбаатар хотод хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч нарын үйл ажиллагаанд хийсэн хэмжилт, шалгалтын тайлан, санал дүгнэлт”-ийн талаар танилцуулга; Улс хоорондын шуудан илгээмжийн зөрчлийн талаар танилцуулга мэдээлэл; “ХХЗХ-ны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит”-ын дүгнэлт, санал зөвлөмжийн талаар танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай зэрэг нийтдээ 10 гаруй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Энэхүү хуралдаан нь хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 7 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 2 тэмдэглэлээр хугацаатай үүрэг, даалгавар холбогдох газар, хэлтэст үүрэг болголоо.

- Хорооны 2019 оны ээлжит 2 дугаар хуралдаанаар “Харилцаа холбооны хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн системийн техникийн нөхцөл, шаардлага тогтоох журам” батлах тухай танилцуулга, тогтоолын төсөл, журмын төслийг авч хэлэлцээд, журмын төслийг хууль тогтоомжид нийцүүлэх талаар нарийвчлан судлах, ХЗДХЯ, УБЕГ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний зөвлөл, ЦЕГ зэрэг холбогдох байгууллагаас албан тоотоор санал авч тусган боловсруулж, хорооны хуралдаанд дахин хэлэлцүүлэхийг ажлын хэсэгт даалгасан билээ. Ажлын хэсгээс дээрх хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгавр, удирдамжийн дагуу яам, байгууллагаас саналын авч тусган боловсруулсан журмын танилцуулга, баримт бичгийн төсөл, тогтоолын төслийг 2019 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдаанд тус тус хэлэлцүүлэв. Тус хуралдаанаас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дах заалтыг тус тус үндэслэн **2019 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 13 тоот тогтоолыг баталж**, уг тогтоолын хавсралтаар “Харилцаа холбооны хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн системийн техникийн нөхцөл, шаардлага тогтоох журам”-ыг батлав. Энэхүү журам батлагдснаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.3 дахь “ хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн техникийн нөхцөл, шаардлага”-ыг үндэслэн иргэд харилцаа холбооны ухаалаг хэрэглэгчийн төхөөрөмжийг сайн дурын үндсэн дээр бүртгэлжүүлэх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бүртгэлийн системд бүртгэгдсэн ухаалаг төхөөрөмжийн алдагдсан, гээгдсэн тохиолдолд хайх, мэдээлэх үйл ажиллагааг зохицуулах боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байна.
- Хорооны 2019 оны ээлжит 4 дүгээр хуралдаанд Захиргаа удирдлага, хамтын ажиллагааны газар болон Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газраас “Богино зайн радио холбооны тоног төхөөрөмжид ашиглах радио давтамжийн хуваариалалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэн боловсруулсан танилцуулга, тогтоолын төсөл, хавсралт баримт бичгийн төслийг хэлэлцүүлэв. Хуралдаанаас энэхүү хэлэлцсэн асуудлаар Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.3 дэх заалт, 9.1.10 дах заалтуудыг үндэслэн **2019 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор** “Богино зайн радио холбооны тоног төхөөрөмжид ашиглах радио давтамжийн хуваариалалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэн тогтоож, тогтоолын хавсралтаар батлан шийдвэрлэв. Энэхүү баримт бичиг нь Монгол улсад ашиглагдах Харилцаа холбооны богино зайн радио холбооны тоног төхөөрөмжүүдийн (БЗРХТТ) нэвтрүүлэх болон хүлээн авах радио давтамжийн хязгаар, гаралтын чадлын техникийн параметрууд, үйл ажиллагаа явуулах хүрээний хамгийн бага шаардлагыг шинэчлэн баталсан байна. БЗРХТТ-ийн радио давтамжийн хуваариалалт, техникийн нөхцөл, шаардлагууд нь нийтдээ 15 хавсралтаар тодорхойлогдсон. Үүнд: Өгөгдөл дамжуулах тоног төхөөрөмжүүд;



Аврах, илрүүлэх тоног төхөөрөмжүүд; Өргөн зурвасын өгөгдөл дамжуулах; Төмөр замын холбооны сүлжээний тоног төхөөрөмжүүд; Зам тээвэр ба ачааллын телематик; Радио илрүүлэгч; Дохиолол; Загварын хяналт; Индукцийн систем; Сонсголын аппарат болон радио микрофон; Радио давтамжаар таних систем; Эмнэлгийн тоног төхөөрөмжүүд; Утасгүй дууны тоног төхөөрөмжүүд; Ультра өргөн зурвасын (UWB) тоног төхөөрөмжүүд; Интернет протокол ашиглан өгөгдөл дамжуулах тоног төхөөрөмж буюу Зүйлсийн интернетийн тоног төхөөрөмжүүд (IoT) зэрэг болно. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2015 оны 50 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2017 оны 44 дүгээр тогтоол, 2018 оны 34 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болгосон.

- Тус хорооны Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газраас “Орон нутагт хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалтыг батлах тухай” танилцуулга, тогтоолын төсөл, хуваарилалтын баримт бичгийн төслийг боловсруулан хорооны хуралдаанд хэлэлцүүлсэн бөгөөд Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дах заалт, 9.1.10 дах заалт, Радио долгионы тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн **2019 оны ээлжит 4 дүгээр хуралдааны 15 тоот** тогтоолын хавсралтаар “Орон нутагт хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт /FM/ ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт”-ыг батлан шийдвэрлэсэн. Энэхүү зурвасын хуваарилалтыг баталснаар Харилцаа Холбоо, Мэдээллийн Технологийн Газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 27 өдрийн А/59 тоот тушаалын хавсралтаар баталсан **“Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”** баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, хөдөө орон нутагт хэт богино долгионы радиогийн өргөн нэвтрүүлгийн (FM) аналогийн радио станцад ашиглах радио давтамжийн зурвасыг хуваарилах, радио давтамжийг үр дүнтэй ашиглах техникийн нөхцөл, шаардлагыг тогтоосон болно.
- Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 43 дугаар тогтоолоор “Нэвтрүүлэх болон хүлээн авах антенны төхөөрөмжийг бүртгэлжүүлэх нөхцөл, шаардлага”-ыг тогтоож хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү баримт бичгийг ХЗДХЯ-д хүргүүлэн санал зөвлөмжийг албан тоотгоор авсан бөгөөд иус яамны зөвлөмжид Захиргааны ерөнхий хуулинд нийцүүлэх, “бүртгэлжүүлэх” гэсэн харилцааг тогтоож, улмаар энэ харилцааны хүрээнд антенны хаягийн байршил, хаягийг шинэчлэх, хаягийн зардал, бүртгүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээг журамлан тогтоосон, мөн журмын 7.2 дахь заалтаар “Энэхүү нөхцөл, шаардлага нь батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр болно.” гэж заасан байгаа зэрэг нь Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2-т “тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх;” гэсэн шаардлагыг хангаагүй байна гэсэн болно. Иймээс тус яамнаас ирүүлсэн зөвлөмж, Захиргааны ерөнхий хуульд баримт бичгийг нийцүүлэх зорилгоор Захиргаа удирдлага, хамтын ажиллагааны газар болон Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газар хамтран “Нэвтрүүлэх болон хүлээн авах антенны төхөөрөмжийг бүртгэлжүүлэх нөхцөл, шаардлага”-ын шинэчилэн боловсруулсан төсөл, танилцуулга, тогтоолын төслийг боловсруулжээ. Тус хуралдаанаар энэхүү асуудлыг авч хэлэлцээд, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дэх заалт, Радио долгионы тухай хуулийн 15.1 дэх заалт, 15.2 дах заалтуудыг тус тус үндэслэн “Нэвтрүүлэх болон хүлээн авах антенны төхөөрөмжийг бүртгэлжүүлэх нөхцөл, шаардлага”-ыг хуралдааны **2019 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 16 тоот тогтоолоор тогтоож**, энэхүү тогтоолын хавсралт ёсоор баталсан болно. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2017 оны 43 дугаар тогтоол, 2017 оны 51 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болгов. Уг баримт бичгийг баталснаар антенны төхөөрөмжийг бүртгэлжүүлэх нөхцөл, шаардлагыг тогтоож, радио давтамжийг үр дүнтэй ашиглах, ашиглалт



үйлчилгээний нөхцөл, шаардлагыг тодорхойлж, хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж байна.

- Зохицуулах хорооны 2019 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн хуралдаанд ажлын хэсгээс боловсруулсан “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлагын хэрэгжилт, телевиз сувгийн хөтөлбөрийн мониторингийн 2018 оны нэгдсэн дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналын тухай” танилцуулга”, хорооны хуралдааны тэмдэглэлийн төслийг хэлэлцүүлэв. Тус хуралдаанаас 2019 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн “Хууль тогтоомж, зохицуулалтын баримт бичгийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” хорооны хуралдааны 08 дугаар тэмдэглэлийг гаргаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар удирдамж, чиглэл үүрэг даалгавар өглөө. Тэмдэглэлд, хорооны 2015 оны 15 тоот тогтоолоор батлагдсан “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгддэг өргөн нэвтрүүлгийн телевиз, кабелийн сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрийн байнгын хяналт, мониторингийн 2018 оны дүн, танилцуулга, зар сурталчилгааны хэтрэлтийн зөрчил, үндэсний нэвтрүүлгийн хувь хэмжээний шаардлагад хүрээгүй зөрчил, баннер гаргасан зөрчил, авах арга хэмжээний саналын тухай танилцуулга, хуралдааны тэмдэглэлийн төслийг хэлэлцээд, дээрх зөрчилүүд нь хууль, тогтоомж, дүрэм, журам, тусгай зөвшөөрлийн гэрээ, нөхцөл шаардлага зөрчсөн эсэхэд дүгнэлт гаргуулахаар Харилцаа холбооны улсын байцаагчид хүргүүлэх, дүгнэлтийг тус хорооны ээлжит хуралдаанд танилцуулах, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газар, Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газарт тус тус үүрэг болгов. Түүнчлэн тус хорооны 2015 оны 15 тоот тогтоолоор батлагдсан “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”, “Өргөн нэвтрүүлэгт насны ангилал тогтоох, таних тэмдэг ашиглах шаардлага” MNS 6587:2016 стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгддэг өргөн нэвтрүүлгийн телевиз, кабелийн сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрийн байнгын хяналт, мониторингийн 2018 оны дүн, танилцуулга, нэр бүхий телевиз, сувгийн хөтөлбөрт илэрсэн 18 наснаас дээш насныханд зориулсан кино, нэвтрүүлгийг өглөө 6:00-22:00 цагийн хооронд дамжуулсан зөрчил, авах арга хэмжээний саналын тухай танилцуулга, хуралдааны тэмдэглэлийн төслийг хэлэлцээд, харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэлийн стандарт, техник, технологийн нөхцөл, горимыг зөрчсөн асуудалд Зөрчлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5, 14.1.9.1, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 1.8.6.10, 2.3 дугаар зүйлийн 2.3.1.1, 2.3.1.3-ын дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, тэмдэглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнан ажиллахыг холбогдох газар, хэлтсийн удирдлагад тус тус даалгав.
- Монгол Улсын Харилцаа Холбооны Зохицуулах хороо нь хууль, тогтоомжийн хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт үйлчилгээ эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс Үндэсний Статистикийн Хороо болон ХХЗХ-ны Даргын нарын хамтран баталсан 15 төрлийн маягтын дагуу хагас, бүтэн жилээр салбарын мэдээлэл, үндсэн үзүүлэлтүүдийг нэгтгэн ЗГХЭГ, холбогдох яам, төрийн байгууллага, олон нийтэд тогтмол танилцуулж, дүн шинжилгээ хийдэг болно. Тус хуралдаанаар Монгол Улсын харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын 2018 оны жилийн эцсийн нэгдсэн статистик үзүүлэлт, тайлангийн тухай танилцуулгыг хэлэлцээд, хуралдаанаас харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын статистик мэдээллийн хамрах хүрээг зөвхөн ХХЗХ-ноос тусгай зөвшөөрөл бүхий иргэн, хуулийн этгээдээс гадна мэдээллийн технологи, программ хангамж, томоохон аж ахуй, байгууллагын мэдээллийн сүлжээ, техник технологи, бүтээгдэхүүний борлуулалт, хөрөнгө оруулалт, орлогын зэрэг статистик мэдээллийг авч нэгтгэн боловсруулах үүрэг бүхий ХХМТГ, ХХЗХ-ны хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллах; холбогдох маягт загварыг шинээр боловсруулах, шинэчлэн



- сайжруулах, хорооны зүгээс ХХМТГ, ҮСХ, УБЕГ, Татварын ерөнхий газар, Мэдээллийн технологийн үндэсний парк, салбарын ТББ-тай хамтын ажиллагаа, үйл ажиллагаагаа улам уялдуулах; тайлагнах талаар цаашид анхаарч ажиллахыг Зах зээл, үнэ тарифын үнэлгээ, судалгааны газарт даалгав.
- Тус хуралдаанд Төрийн аудитын тухай хуулийн 15.1, 18.2 заалт, Төсвийн тухай хуулийн 8.9.1 заалт болон Хорооны даргаас өгсөн удирдамж, чиглэлийн хүрээнд “ХХЗХ-ны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит”-ын дүгнэлт, санал зөвлөмжийн талаар танилцуулга, хуралдааны тэмдэглэлийн төслийн авч хэлэлцээд, 2019 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 9 дүгээр хуралдааны тэмдэглэлээр Зохицуулах хорооны 2018 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн хувьд холбогдох хууль тогтоомж, журам зааврын дагуу “зөрчилгүй санал, дүгнэлт” гэж Аудитын гэрчилгээнд илэрхийлсэн байдал, аудиторын өгсөн зөвлөмжийг цаашид хэрэгжүүлж ажиллахыг Төсвийн захирагч буюу Хорооны даргад үүрэг болгохоор тогтов.
 - Тус хорооны хуралдаанаар “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, дүгнэлт болон тогтоолын төслийг авч хэлэлцэв. Энэхүү хэлэлцсэн асуудлаар 3 тогтоолыг батлан шийдвэрлэв:
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 3 ААН, хуулийн этгээдэд **2019 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 17 тоот тогтоолын** хавсралтаар 3 тусгай зөвшөөрөл шинээр олгосон;
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2 дах хэсэг, 10.3.1, 10.3.3 дах заалтыг тус тус үндэслэн **2019 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 18 тоот тогтоолын** 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан;
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 12.1.1 дах заалтыг тус тус үндэслэн **2019 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 19 тоот тогтоолоор** 8 хуулийн этгээдийн 9 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэсэн болно.
 - Хуралдааны үеэр хорооны нэр бүхий гишүүдээс гаргасан санал, шүүмжийн дагуу тус хуралдаанаас тусгай зөвшөөрөл олгох асуудлаар хэлэлцүүлсэн нэр бүхий 20 хуулийн этгээдийн асуудлыг ойрын үед буюу 2019 оны ээлжит бус хуралдаанаар дахин авч хэлэлцэх; тусгай зөвшөөрлийн асуудлаар ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийн материалд үнэлгээ, дүгнэлт гаргаж байгаа маягт, процесс үйл ажиллагааг боловсронгуй болгох, хорооны чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд үзүүлж байгаа тусгай зөвшөөрлийн үйлчилгээний нөхцөл шаардлагын мөрдүүлэх, зөвшөөрлийн талаар



цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар саналаа боловсруулан ойрын үед Хорооны ээлжит бус хуралдаанд танилцуулахыг ЗУХАГ, холбогдох газруудад тус тус үүрэг болгов.

- Тус хуралдаанаар “Улс хоорондын шуудан илгээмжийн зөрчлийн талаар танилцуулга мэдээлэл”-ийг Шуудангийн зохицуулалтын газар, Гаалийн ерөнхий газрын Улс хоорондын шуудан, илгээмжийн гаалийн газар хамтран хийсэн бөгөөд улс ххорондын шуудангийн илгээмжээр хууль бус бараа нэвтрүүлэх, татвараас залсхийх зэрэг асуудлаар гарч байгаа зөрчил дутагдлыг илрүүлэх, арилгах талаар төр (ГЕГ, ХХМТГ, ХХЗХ), тусгай зөвшөөрөл бүхий хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд үйл ажиллагааны болон ажлын уялдаа холбоог сайжруулах, ГЕГ-аас ХХМТГ, ХХЗХ-нд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний цогц саналаа албан ёсоор ирүүлэх, ХХЗХ-ноос холбогдох дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах нь зүйтэй гэж үзэв.

5. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны ээлжит бус 01 дүгээр хуралдаан 2019 оны 5 дугаар сарын 14-ний өдөр болов. Тус хуралдаанаар “Харилцаа холбооны салбарын зохицуулалт, цаашдын чиг хандлагууд” танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай; бусад зэрэг асуудлыг хэлэлцэн хорооны хуралдааны 2 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 1 тэмдэглэлээр хугацаатай үүрэг, даалгавар холбогдох газар, хэлтэст үүрэг болгосон.

- Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны ээлжит бус 01 дүгээр хуралдаанд Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, зохицуулалтын хэлтсийн дарга А.Лувсан-Очир “Харилцаа холбооны салбарын зохицуулалт, цаашдын чиг хандлагууд” сэдэвт танилцуулга хийлээ. Үүнд: Гадаад улс орнуудын МХХТ-ийн хөгжлийн гол чиг хандлагууд, зохицуулалтын хөгжлийн үе шатууд, зохицуулалтын үндсэн зарчмууд, шалгуур үзүүлэлтүүд, зохицуулалтын гадаад дотоод орчины өөрчлөлт хувьсал, учирч буй хүндрэл бэрхшээл, цаашид авч хэрэгжүүлэх зохицуулалтын арга хэмжээний санал, дүгнэлтүүд зэрэг сэдвийг хамруулсан болно.
- Хуралдааны 2019 оны ээлжит 4 дүгээр хуралдааны үеэр хорооны нэр бүхий гишүүдээс гаргасан санал, шүүмжийн дагуу тусгай зөвшөөрөл олгох асуудлаар хэлэлцүүлсэн нэр бүхий 20 хуулийн этгээдийн асуудлыг хойшлуулж, 2019 оны ээлжит бус хуралдаанаар дахин хэлэлцүүлэх; тусгай зөвшөөрлийн асуудлаар ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийн материалд үнэлгээ, дүгнэлт гаргаж байгаа маягтыг өөрчлөх талаар ЗУХАГ, холбогдох газруудад тус тус үүрэг болгосон юм. Иймээс ажлын хэсгээс 2019 оны ээлжит бус 01 дүгээр хорооны хуралдаанд тусгай зөвшөөрлийн асуудлыг оруулах маягтын шинэчилсэн загварыг танилцуулж, тусгай зөвшөөрөл нэг бүрээр хэлэлцүүлэв. Тус хорооны 2019 оны ээлжит бус 01 дүгээр хуралдаанаар “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай” газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, дүгнэлт болон тогтоолын төслийг авч хэлэлцэв. Энэхүү хэлэлцсэн асуудлаар 2 тогтоолыг батлан шийдвэрлэв:
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 23 ААН, хуулийн этгээдэд **2019 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 20 тоот тогтоолын** хавсралтаар 23 тусгай зөвшөөрөл шинээр олгосон;



- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2 дах хэсэг, 10.3.1, 10.3.3 дах заалтыг тус тус үндэслэн **2019 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 20 тоот тогтоолоор 5** хуулийн этгээдийн 5 тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан;
6. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны ээлжит 5 дугаар хуралдааныг 2019 оны 5 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж, хуралдаанаар Харилцаа холбооны зохицуулах хорооны хууль эрхзүйн акт, баримт бичгийн талаар танилцуулга; “Радио давтамжийн төлбөрийн журам, төлбөрийг шинэчлэх санал боловсруулах” ажлын хэсгийн тайлангийн танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай; бусад асуудал зэрэг 4 асуудлыг хэлэлцэв. Тус хуралдаан нь хэлэлцсэн дээрх асуудлаар хорооны хуралдааны 1 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 1 тэмдэглэлээр удирдамж чиглэл, хугацаатай үүрэг, даалгаварыг холбогдох газар, хэлтэст үүрэг болгон даалгав.
- Зохицуулах хорооны 2019 оны ээлжит 1 дүгээр хуралдааны 01 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу “Харилцаа холбооны зохицуулах хорооны хууль эрхзүйн акт, баримт бичгийн талаар танилцуулга”-ыг хуралдаанаар хэлэлцээд, хорооны тогтоол шийдвэр, зохицуулалтын баримт бичгийг Захиргааны ерөнхий хууль, холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэх арга хэмжээний хэрэгжилт, тайлан үр дүн болон зохицуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн чиглэлээр шийдвэрлэх шаардлагатай байгаа асуудлууд, хувилбар шийдлийн талаар удирдамж чиглэл өгч, асуудлыг дахин боловсруулах талаар холбогдох газар хэлтэст үүрэг болгов. Харилцаа холбооны зохицуулах хорооны хэмжээнд 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар, ХХЗХ-ны хуралдаанаар баталсан хүчин төгөлдөр мөрдөж буй тогтоол, шийдвэрийн нийтдээ 77 эрх зүйн зохицуулалтын баримт бичиг байгаа бөгөөд үүнээс, Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн хорооны тогтоолоор шинэчлэн баталж ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн санд хянуулан бүртгүүлсэн 9 захиргааны хэм хэмжээний акт (ХХЗХ-ны 2017 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан 2 баримт бичиг болон 2017 оны 18, 31, 32, 58 дугаар тогтоол, 2018 оны 17, 23, 24 дүгээр тогтоол); Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн санд бүртгүүлэх шаардлагагүй 10 баримт бичиг (Тухайлбал, Дэд бүтцийн сайдын 2003 оны 39 дүгээр тушаал болон 216 дугаар тушаал болон ХХЗХ-ны 2012 оны 06 дугаар, 2014 оны 19 дүгээр, 44 дүгээр, 59 дүгээр, 2015 оны 41 дүгээр, 2016 оны 01 дүгээр, 43 дугаар, 2018 оны 04 дүгээр тогтоол) зэрэг болно.
 - Хорооны Даргын 2018 оны А/77 тоот тушаалаар “Радио давтамжийн төлбөрийн журам, төлбөрийг шинэчлэх санал боловсруулах” ажлын хэсгийг байгуулсан. Тус хуралдаанд ажлын хэсгээс олон улсын спектрийн зохицуулалт, зорилго; Монгол улсын радио спектрийн зохицуулалт, хуваарилалт, ашиглалт; олон улсын спектрийн төлбөрийн арга, аргачлал; Монгол улсын радио спектрийн төлбөрийн аргачлал, үнэлгээ болон дүгнэлт, зөвлөмжийн талаар танилцуулгыг хэлэлцүүлсэн. Радио спектр нь хүний үйл ажиллагаанаас ангид оршдог байгалийн баялаг, түүний бодит тоо хэмжээ нь хязгаарлагдмал учраас ховор нөөц баялаг гэж мэргэжилтнүүд үздэг юм. Үүнд: нийт давтамжийн нөөц нь байгалийн ба физикийн үзүүлэлтээр тодорхойлогддог; ашиглах боломжтой баялгийн нөөц нь эдийн засгийн ба техникийн



хүчин зүйлээр тодорхойлогддог (ялангуяа харьцангуй зардлын өсөлтөөс); ашиглагдаж буй баялгийн нөөц нь эдийн засаг ба техникийн нөхцөл байдлаар хэмжигддэг зэрэг болно. Хуралдаанаас ажлын хэсгийн санал, зөвлөмжийг зарчмын хувьд дэмжээд, олон улсын радио спектрийн зохицуулалт, хуваарилалт, ашиглалт; спектрийн төлбөрийн тооцооны аргачлалын загвар, жишиг болон тэргүүн туршлагыг судлан харьцуулах, хоёр талын болон олон улсын хамтын ажиллагааны хүрээнд гадаад, дотоодын зөвлөх үйлчилгээ авах талаар судлах, цаашид Радио долгионы тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан санал зөвлөмжид тусгах талаар ажлын хэсэгт үүрэг чиглэл болгов.

- Тус хорооны хуралдаанаар тусгай зөвшөөрлийн талаар авах зарим арга хэмжээний тухай (МЦХ ХК) танилцуулга, хорооны хуралдааны тэмдэглэлийн төсөл, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 300 дугаар тогтоол, ЗГХЭГ-аас ирүүлсэн 2019 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн ХЭГ/ 311 тоот албан бичиг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ирүүлсэн 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн А-1/721 тоот албан бичиг, Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци ТББ-аас ирүүлсэн 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 13 тоот албан бичиг, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас ирүүлсэн 2019 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 1/294 тоот бодлогын чиглэлийг тус тус авч хэлэлцээд, МЦХ ХК-ийн тусгай зөвшөөрөлтэй холбогдох асуудлыг шийдвэрлэх талаар удирдамж, чиглэл өгөх тухай Хорооны хуралдааны 2019 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 10 дугаар тэмдэглэл гаргах нь зүйтэй гэж тогтов. Тэмдэглэлд, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралтаар МЦХ ХК-д олгосон “Утасгүй интернэтийн үйлчилгээнд радио давтамж ашиглах” тусгай зөвшөөрлийн дагуу гэрээ байгуулах, гэрчилгээ олгох асуудлыг зохион байгуулах; МЦХ ХК-тай уг тусгай зөвшөөрлийн гэрээг байгуулахдаа тус компаниас ирүүлсэн санал хүсэлт, компаний санхүүгийн өнөөгийн хүндрэлтэй нөхцөл байдал, холбогдох байгууллагаас ирүүлсэн бодлогын чиглэлийг тус тус үндэслэн тусгай зөвшөөрлийн нэг удаа төлөх төлбөрийг 5 жилийн хугацаатай хойшлуулж, 2024 оноос эхлэн 5 жилийн хугацаанд хуваарийн дагуу бүрэн барагдуулах асуудлыг нарийвчлан тусгах зэрэг удирдамж, чиглэлийг баримтлан ажиллахыг холбогдох бүтцийн нэгжид даалгалаа.

- Тус хорооны хуралдаанаар “Тусгай зөвшөөрөл олгох тухай” газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, дүгнэлт болон тогтоолын төслийг авч хэлэлцэв. Энэхүү хэлэлцсэн асуудлаар 1 тогтоолыг батлан шийдвэрлэсэн. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 10 ААН, хуулийн этгээдэд **2019 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 22 тоот тогтоолын** хавсралтаар 10 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон.

7. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны ээлжит 6 дугаар хуралдааныг 2019 оны 6 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулав. Тус хуралдаанаар Өр авлагатай тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын талаар авах зарим арга хэмжээний тухай; Тусгай зөвшөөрлийн тухай зэрэг 2 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Хуралдаан хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 2 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 1 тэмдэглэлээр удирдамж чиглэл, хугацаатай үүрэг, даалгаварыг холбогдох газар, хэлтэст үүрэг болгов.



- ХХЗХ-ноос харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулах журмын 6.4 (Дараах жилүүдийн төлбөрийг олгосон тухай шийдвэр гарсан тухайн жилийн өдрөөс 1 сарын өмнө төлсөн байна.) заасан дагуу гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй; 2018 оны жилийн эцсийн тайлангаар зөвшөөрлийн төлбөрийн үлдэгдэл өртэй зөвшөөрөл эзэмшигч нарт удаа дараа мэдэгдэж, улмаар 2019 оны 2 дугаар сарын 14-ны өдрийн 02/200 албан тоотой үүссэн өр төлбөрөө барагдуулах хугацааг 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр хүртэл олгосон юм. Уг албан тоот, мэдэгдлийн дагуу зөрчлөө арилгаагүй тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, хуулийн этгээд нарт Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-ийн дагуу сонсгол хийх тухай 2019 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 02/629 албан тоотой мэдэгдлийг хүргүүлж, 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хүртэл зөрчлөө арилгах, төлбөрөө барагдуулах хугацааг дахин хойшлуулж, Харилцаа холбооны тухай хуулийн 15.2-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос учирсан хохирлыг Зохицуулах хороо хариуцахгүй тухай мэдэгдлийг тус тус хүргүүлсэн болно. Иймээс тусгай зөвшөөрлийн гэрээний заалт, үүргээ биелүүлээгүй; үйлчилгээний тусгай зөвшөөрлийн болон радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийг хугацаанд нь төлөөгүй нэр бүхий 63 иргэн, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нийт 90 радио давтамж ашиглах болон үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай, тусгай зөвшөөрлийн талаар цаашид авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний саналыг тус тус авч хэлэлцээд, Харилцаа холбооны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 25 дугаар зүйлийн 25.2.10 дах заалт, Радио долгионы тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дах заалт, 19 дүгээр зүйлийн 19.2.3 дах заалт, Шуудангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.5 дах заалт, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дах заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 12.1.4 дэх заалт болон тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулсан зөвшөөрлийн гэрээний холбогдох зүйл, заалтыг тус тус үндэслэн **Хорооны 2019 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” 23 тоот тогтоолыг баталж**, энэхүү тогтоолын хавсралтаар нэр бүхий 63 иргэн, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нийт 90 радио давтамж ашиглах болон үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгов.
- Зохицуулах хорооны хуралдаанд “Тусгай зөвшөөрөл олгох тухай” газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, дүгнэлт болон тогтоолын төслийг хэлэлцээд, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн **2019 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 24 тоот тогтоолыг баталж**, энэхүү тогтоолын хавсралтаар 8 ААН, хуулийн этгээдэд 8 тусгай зөвшөөрлийг тус тус шинээр олгов.
8. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны ээлжит 7 дугаар хуралдаан 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдөр зохион болсон ба тус хуралдаанаар “Харилцаа холбооны тухай” хууль, “Радио долгионы тухай” хууль, “Шуудангийн тухай” хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан талаар танилцуулга мэдээлэл; ХХЗХ-ны тогтоолоор баталсан эрхзүйн баримт бичгийн судалгаа (2003-2019 он), цаашид авч хэрэгжүүлэх төлөвлөгөө, арга хэмжээний тухай;



“Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын явцын талаар танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай зэрэг 5 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Энэхүү хуралдаан нь хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 3 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 1 тэмдэглэлээр хугацаатай үүрэг, даалгавар холбогдох газар, хэлтэст үүрэг болголоо. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын чуулганы 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар “Харилцаа холбооны тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай; “Радио долгионы тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай; “Шуудангийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиудыг соёрхон баталсан билээ. Эдгээр салбарын суурь эх зүйн баримт бичгүүдийн нэмэлт, өөрчлөлтүүд болон хэрэгжүүлж эхлэхэд үүсэх шинэ эрх зүйн орчин дахь бодлого, зохицуулах байгууллагын бүрэн эрх чиг, үүргийн нэмэлт өөрчлөлт, шинэчлэлтийн зэрэг асуудлаар танилцуулга мэдээллийг хорооны хуралдаанд УИХ-ын дэргэд байгуулсан ажлын хэсгийн гишүүн, ХХЗХ-ны хэлтсийн дарга А.Лувсан-Очир хийлээ. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд төрийн бодлого, зохицуулалтын чиг үүргийн ялгаа заагийг тодорхой болгон, салбарын үр ашигтай шударга өрсөлдөөнийг дэмжих бодлого зохицуулалтыг хөгжлийн шинэ шатны зорилго зорилтуудад нийцүүлэн сайжруулах асуудлыг тусгажээ. Радио долгионы тухай хуульд хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд радио долгионы үзүүлэх сөрөг нөлөөллийг хязгаарлах, радио давтамжийн ашиглах эдийн засгийн үр өгөөжийг нэмэх, нэр томьёог олон улсын гэрээ, конвенц, Дэлхийн радио холбооны дүрэмтэй нийцүүлсэн юм. Мөн Дэлхийн радио холбооны их хурал, бүсийн бэлтгэл хуралд бэлтгэх, радио долгионы улс хоорондын зохицуулалт хийх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, мэргэжлийн санал дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл байгуулах, түүнийг эрх зүйн байдлыг тодорхойлсон. Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар шуудангийн үндсэн сүлжээний тодорхойлолт, эзэмшигчийн статусыг олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлох, шуудангийн нэгдсэн кодын тодорхойлолт, хүргэлтийн давтамж, чиглэл болон хугацааг дэлхийн жишигт нийцүүлэхээр баталсан байна.
- Энэхүү ээлжит хуралдаанд тус хорооны Даргын 2019 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн А1136 тоот тушаалаар томилогдсон ажлын хэсгээс “Харилцаа холбооны зохицуулах хорооны тогтоолоор баталсан эрхзүйн баримт бичгийн судалгаа (2003-2019 он), цаашид авч хэрэгжүүлэх төлөвлөгөө, арга хэмжээний тухай” танилцуулгыг хэлэлцүүлэв. Ажлын хэсгийн мэдээлэлд, Зохицуулах хороо нь 2003 оноос 2019 оны 7 дугаар сарын эцэс хүртэлх хугацаанд нийтдээ 187 зохицуулалтын баримт бичгүүд (дүрэм, журам, радио давтамжийн хуваарилалт төлөвлөлт, техникийн нөхцөл шаардлага, үнэ тариф, аргачлал г.м)-ийг баталсан байна. 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар, нийт хүчин төгөлдөр үйлчилж буй, зохицуулах хорооны тогтоолоор баталсан 73 эрх зүйн баримт бичиг хүчин төгөлдөр байгаа ба үүнээс ХЗДХЯ-нд бүртгүүлэх шаардлагатай нийт 47 баримт бичиг, бүртгүүлэх шаардлагагүй 26 баримт бичиг, бүртгүүлсэн 10 баримт бичиг, бүртгүүлэх шаардлагатай 37 байна гэсэн судалгааг ажлын хэсгээс гаргажээ. Түүнчлэн “Харилцаа холбооны тухай” хууль /ХХТХ/, “Радио долгионы тухай” хууль /РДТХ/, “Шуудангийн тухай” хуулиудад /ШТХ/ нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан шинээр боловсруулан дараахь зохицуулалтын баримт бичгийг батлах шаардлагатай байгаа болно. Үүнд: Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдсон журам батлах /ХХТХ 9.1.6/; Радио, телевизийн болон тэдгээрийг дамжуулах үйлчилгээний нөхцөл, шаардлага батлах /ХХТХ 9.1.10/; Домэйн нэрийг бүртгэх, ашиглахтай холбогдсон журам батлах /ХХТХ 9.1.14/; Тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэх харилцаа холбооны үйлдвэрлэл, ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбоотой журам батлах /ХХТХ 9.1.15/; Дотоодын хэрэглээний холбооны сүлжээнд зохицуулалт хийх журам батлах /ХХТХ 21.2/;



Цахилгаан соронзон орны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшиний хэмжилт хийх аргачлал батлах /РДТХ 5.1.7/; Радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж ашиглах журам батлах /РДТХ 5.1.9/; Радио төхөөрөмж ажиллуулах, үйл ажиллагааг нь зогсоох, хориглох журмыг батлах /РДТХ 20.6/; Шуудангийн харилцан холболтын журам батлах /ШТХ 9.1.5/; Шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоож, мөрдүүлэх /ШТХ 9.1.6/ зэрэг болно. Тус хуралдаанаар ажлын хэсгийн гүйцэтгэсэн судалгааны дүн шинжилгээний үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг зарчмын хувьд дэмжиж, салбарын суурь хуулиудын нэмэлт өөрчлөлтийн дагуу зохицуулалтын баримт бичгийг нийцүүлэн шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох арга хэмжээг Хорооны хуралдаанд 2019 онд багтаан тухай бүр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг тайлагнан ажиллахыг ажлын хэсэгт үүрэг чиглэл болгов.

- Зохицуулах хорооны хуралдаанд 2019 оны ээлжит 2 дугаар хуралдааны 06 дугаар тэмдэглэл, ээлжит 4 дүгээр хуралдааны 06 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын явцын талаар танилцуулгыг хэлэлцүүлсэн. Энэхүү танилцуулга нь өргөн нэвтрүүлгийн зохицуулалтыг хэрэгжүүлэх чиглэлээр 2019 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн гол ажлууд; “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-д нэмэлт өөрчлөлт оруулах чиглэлээр хийгдэж байгаа ажлууд; УБ хотын телевиз, суваг Радиогийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн чиглэлээр хийгдэж байгаа ажлууд, УБ хотын телевиз, сувгийн хяналт, шалгалтын талаарх товч мэдээлэл зэргээс бүрдсэн болно. ХХЗХ-ноос ӨНЗНШ-д нэмэлт өөрчлөлт оруулж төслийг УБ хотын үйлчилгээ эрхлэгчидтэй уулзалт зохион байгуулж, танилцуулсан. Бүх үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлж, цахим хуудсанд нээлттэй тавьж, саналыг авсан болно.
- УБ хотын телевиз, сувгуудад хийсэн хяналт шалгалтын үеэр нийт 60 гаруй ТВ, сувгуудын удирдлага, программын албаны дарга нартай уулзаж, нөхцөл шаардлагад оруулах өөрчлөлтийн талаар танилцуулж, санал бодлыг сонсож ажилласан байна. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн төслийг УИХ-ын Хуралдаанаар хэлэлцэхээр 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдөр шийдвэрлэсэн болно. Өргөн нэвтрүүлгийн хуулийн төсөл дээр ажиллах дэд ажлын хэсэгт нэрсээ өгч, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн төслийг дахин хянаж, саналыг үндэслэлийн хамт тусгах ажлыг хийж байгаа талаар танилцуулав. Хуралдаанаас хэлэлцсэн танилцуулга мэдээлэл болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбогдох удирдамж, чиглэлийг ажлын хэсэгт өгөв.
- Тус хорооны хуралдаанаар “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, дүгнэлт болон 3 тогтоолын төслийг авч хэлэлцэв. Энэхүү хэлэлцсэн асуудлаар 3 тогтоолыг батлан шийдвэрлэв:
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 11 ААН, хуулийн этгээдэд 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 тоот тогтоолын хавсралтаар 11 тусгай зөвшөөрөл шинээр олгосон;
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 10.1, 10.2 дах хэсэг, 10.3.3 дах заалт, “Монгол Улсын



нутаг дэвсгэрт телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ хүргэхэд тавигдах нөхцөл шаардлага"-ын 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйлийг тус тус үндэслэн 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 26 тоот тогтоолын 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан;

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дах заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.4 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.3 дах заалт, Радио долгионы тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны баталсан "Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам"-ын 12.1.1, 12.1.4 дах заалтыг тус тус үндэслэн 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 тоот тогтоолын 2 иргэн, хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэсэн болно.

9. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны ээлжит 8 дугаар хуралдааныг 2019 оны 8 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулав. Энэхүү хуралдаанаар "Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны хуралдааны дэг"-ийг шинэчлэн батлах тухай; Тогтоол хүчингүй болгох тухай (2012 оны 60 дугаар тогтоол: ХХЗХ-ны ажилтан, албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн дүрэм); Хорооны хуралдаанаар 2019 оны эхний хагас жилд баталсан тогтоол шийдвэр, хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн танилцуулга; Ажлын хэсгээс "Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй телевиз, сувгуудын үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнг үндэслэн авах арга хэмжээний санал"-ыг шийдвэрлүүлэх тухай; "Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам"-ыг шинэчлэн батлах тухай (2013 оны 27 тоот тогтоол); Засгийн газрын 2019 оны 149 тоот тогтоолыг хэрэгжүүлэх тухай; Томоохон өр авлагатай тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын талаар танилцуулга, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай; Тусгай зөвшөөрлийн тухай; Бусад зэрэг 9 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Уг хуралдаан нь хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 7 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 2 тэмдэглэлээр хугацаатай үүрэг, даалгавар холбогдох газар, хэлтэсийн удирдлагад даалгасан.

- Монгол Улсын Засгийн газрын "Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм шинэчлэн батлах тухай" 2016 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тогтоолын хавсралтаар "Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм"-ийг шинэчлэн баталсан. Энэхүү дүрэмд нийцүүлэн хуралдааны дэгийг шинэчлэн боловсруулж, хорооны 2016 оны 43 тогтоолоор "Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг"-ийг шинэчлэн баталж, хорооны 2017 оны 01 тоот тогтоол, 2018 оны 08 тоот тогтоолын хавсралтаар тус тус нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр оруулан баталж өнөөг хүртэл мөрдөж ирсэн болно. УИХ-ын чуулганаар "Харилцаа холбооны тухай" хууль, "Радио долгионы тухай" хууль, "Шуудангийн тухай" хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр соёрхон баталсантай холбогдуулан хорооны бүрэн эрх, чиг үүрэг өргөжин нэмэгдсэн нь "Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг"-д заасан хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлын хамрах хүрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай болсон. Тухайлбал, "Харилцаа холбооны тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар нийтдээ 16 заалт (9 дүгээр зүйлийн 9.1.1-9.1.16); "Радио долгионы тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар 11 (6 дугаар зүйлийн 6.1.1-6.1.11); "Шуудангийн тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар 11 (9 дүгээр зүйлийн 9.1.1-9.1.7) заалтаар зохицуулах хорооны бүрэн эрх, зохицуулалтын баримт бичиг, дүрэм



журам, төлөвлөлт, норм норматив батлах, хэрэгжилтэнд хяналт тавих хэм хэмжээний чиг үүрэгт зарим зарчмын нэмэлт, өөрчлөлт оруулаад байгаа юм. Салбарын эдгээр суурь хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулснаар хорооны бүрэн эрх, хэм хэмжээний өргөжилт болон хуралдаанд бэлтгэх, зохион байгуулах, тогтоол шийдвэрийг албажуулах, баримтжуулах, хэрэгжилтэд хяналт тавих зэрэг үйл ажиллагааг боловсронгуй болгохоор “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийг шинэчлэн боловсруулсан. Иймээс хорооны хуралдааны нарийн бичгийн дарга /Т.Наранмандах/-аас “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийг шинэчлэн батлах үндэслэл танилцуулга, тогтоолын төсөл, баримт бичгийн төслийг боловсруулан тус хуралдаанд хэлэлцүүлэв. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 268 дугаар тогтоолоор баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалт, хорооны гишүүдээс гарсан санал зөвлөмжийг тусган тус хорооны 2019 оны 8 дугаар сарын 19-ны өдрийн “Шинэчлэн батлах тухай” 28 дугаар тогтоолоор “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийг шинэчлэн баталсан. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан хорооны 2016 оны 43 тоот тогтоол, 2017 оны 01 дүгээр тогтоолын хавсралт, 2018 оны 08 тоотын хавсралтыг тус тус хүчингүй болгов.

- Энэхүү хорооны хуралдаанаар “ХХЗХ-ны 2019 оны эхний хагас жилд баталсан тогтоол шийдвэр, хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн тайлан”, холбогдох танилцуулгыг хэлэлцээд, цаашид хуралдааны тэмдэглэлээр өгсөн хугацаатай үүрэг даалгавар, удирдамж чиглэлийн хэрэгжилтэд түлхүү анхаарч, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга /Т.Наранмандах/-д өгөв. Харилцаа холбооны зохицуулах хорооны (2019 оны эхний хагас жил) хуралдааны тогтоол, шийдвэр, хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн талаар нэгтгэсэн мэдээллээс үзэхэд, Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм, хуралдааны дэгийн хүрээнд удирдлагаас өгсөн удирдамж чиглэл, 2019 оны үйл ажиллагааны Бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд буюу 2019 оны эхний хагас жилд, хорооны ээлжит хуралдааныг 6 удаа, ээлжит бус хуралдааныг 1 удаа тус тус зохион байгуулсан ба нийтдээ 24 тогтоолыг батлан шийдвэрлэж, хорооны хуралдааны 11 тэмдэглэлийн биелэлт, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Байгууллагын цахим хуудаст хорооны хуралдааны тогтоолоор хүчингүй болгосон, шинэчлэн баталсан, нэмэлт өөрчлөлтийн мэдээллийг тухай бүр шинэчлэх арга хэмжээг авлаа. Хорооны хуралдаанаар батлагдсан тогтоол, тогтоолын хавсралтуудыг тусгай фолдерт байршуулан албан дотоод хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.
- Тус хорооны 2012 оны 60 тоот тогтоолын хавсралтаар “ХХЗХ-ны ажилтан, албан хаагчдын ёс зүйн дүрэм”-ийг баталсан бөгөөд хүчин төгөлдөр мөрдөж байна. Энэхүү ёс зүйн дүрмийг Төрийн албаны тухай 2018 оны хууль, салбарын суурь хуулиудад 2019 оны 5 дугаар сард нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан, Захиргааны ерөнхий хууль, холбогдох хууль тогтоомжууд, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн жишигт нийцүүлэх зорилгоор хуучин баримт бичгийг хүчингүй болгож, шинэчлэн батлах шаардлага гарсан болно. Байгууллагын ёс зүйн дүрэм нь дотогшоо чиглэсэн баримт бичиг учраас хорооны 2012 оны 60 дугаар тогтоолыг хүчингүй болгож, Хорооны даргын тушаалаар батлан мөрдөх зохицуулалт хийх зорилгоор хорооны хуралдааны тогтоол, тэмдэглэлийн төслийг боловсруулан хэлэлцүүлсэн. Хуралдаанаар уг асуудлыг авч хэлэлцээд, дээр заасан холбогдох хууль тогтоомж, жишиг баримт бичиг, дүрэмд нийцүүлэн байгууллагын ёс зүйн хороог байгуулах, улмаар “ХХЗХ-ны ажилтан, албан хаагчдын ёс зүйн дүрэм”-ийн шинэчилсэн төслийг боловсруулсны дараа Хорооны хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн.



- Холбогдох хууль тогтоомж, ЗГ-ын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор тус хорооны РДХЗГ-аас “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”-ын төсөл, танилцуулга, тогтоолын төслийг боловсруулан хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дах заалт болон Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн хорооны 2019 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам батлах тухай” 29 дугаар тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”-ыг шинэчлэн батлав. Энэхүү журмаар мэдээлэл харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалтыг схемийн дагуу явуулах ерөнхий харилцааны зохицуулалтыг шинэчлэн баталж тогтоосон болно. Журмын хамрах хүрээнд заавал баталгаажуулалт, сайн дурын баталгаажуулалтын 2 төрлийн баталгаажуулалтын үйл ажиллагаа зохицуулна. Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтад заагдсан Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжүүд болон бүх төрлийн радио төхөөрөмжүүд нь заавал баталгаажуулалтад хамрагдаа бөгөөд энэхүү жагсаалтад хамрагдаагүй тоног төхөөрөмжүүдийг сайн дурын баталгаажуулалтад хамруулж болно. Баталгаажуулалтын журмыг шинэчлэн баталснаар мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмж нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлын талаар холбогдох норматив техникийн баримт бичигт тогтоосон шаардлагыг бүрэн хангасныг үнэн зөв нотлох; хэрэглэгчид зөв сонголт хийх боломж олгох, зах зээлд хуурамч болон шаардлагад нийцэхгүй бүтээгдэхүүн Монгол Улсад оруулж ирэх, ашиглахаас хамгаалах ач холбогдолтой юм. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан зохицуулах хорооны 2013 оны 27 тоот тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”; 13 дугаар хавсралтаар баталсан “Баталгаажуулалтад хамруулах мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн ангилал хамрах хүрээ, мөрдөх стандартын жагсаалт”-ыг тус тус хүчингүй болгов.
- Тус хорооны хуралдаанаар “Томоохон өртэй тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаарх танилцуулга, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай”, аудитын компаний зөвлөмж, хорооны хуралдааны тэмдэглэлийн төсөл, Даргын зөвлөлийн 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 02 тоот хуралдааны тэмдэглэл, тусгай зөвшөөрлийн талаар цаашид авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний саналыг тус тус авч хэлэлцээд, хорооны хуралдаанаас 2019 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн “Тусгай зөвшөөрлийн өр төлбөрийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 13 болон 14 дүгээр хуралдааны тэмдэглэлээр хугацаатай үүрэг даалгавар, удирдамж чиглэлийг өгч, холбогдох арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжүүлэн ажиллахыг Дэд дарга, Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газарт тус тус үүрэг болгов.
- Тус хорооны хуралдаанаар “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай”, “Тусгай зөвшөөрөл түдгэдзүүлэх тухай”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, дүгнэлт болон 4 тогтоолын төслийг авч хэлэлцэв. Энэхүү хэлэлцсэн асуудлаар 4 тогтоолыг батлан шийдвэрлэв:
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн



9 хуулийн этгээдэд 2019 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 30 тоот тогтоолын хавсралтаар 9 тусгай зөвшөөрөл шинээр олгосон;

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 10.1, 10.2 дах хэсэг, 10.3.3 дах заалтыг тус тус үндэслэн 2019 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 30 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулсан;
- ХХЗХ-ны Даргын 2019 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/57 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2019 оны 3-6 сарын хугацаанд нийтдээ 74 тусгай зөвшөөрөл эзэмшигч (Өргөн нэвтрүүлгийн ТВ-20, суваг-54) нарын хэмжээнд Харилцаа холбооны тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль; тусгай зөвшөөрлийн гэрээ; өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага; харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам болон бусад баримт бичгийн хэрэгжилт, зөвшөөрлийн үйл ажиллагааны нөхцөл байдал зэргийг газар дээр шалгаж ажилласан болно. Уг ажлын хэсгийн санал, дүгнэлт болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, тогтоолын төслийг хорооны хуралдаанаар хэлэлцээд, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дах хэсэг, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт болон Харилцаа холбооны хяналтын улсын байцаагчийн 2019 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн 57-07-002/14, 57-07-002/15, 57-07-002/17, 57-07-002/18 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн нэр бүхий 4 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсэн хорооны 2019 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 32 дугаар тогтоолыг; Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.1.1 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 12.1.1, 12.1.4 дах заалтыг тус тус үндэслэн 1 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон 2019 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 33 тоот тогтоолыг тус тус батлав.

10. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны ээлжит 9 дүгээр хуралдаан 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр болов. Тус хуралдаанаар “Харилцааны холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай; хорооны хуралдааны 2019 оны 13 дугаар тэмдэглэлийн хэрэгжилт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналын тухай (Жи-Мобайл ХХК-ийн өр төлбөрийн асуудал); “Радио өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх арга хэмжээний тухай” танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай; бусад зэрэг 4 асуудлыг хэлэлцэв. Хуралдаанаас хэлэлцсэн дээрх асуудлаар хорооны хуралдааны 6 тогтоолыг батлан шийдвэрлэв.

- Зохицуулах хорооны 2014 оны 10 тоот тогтоолын хавсралтаар “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ыг батлуулан мөрдөж байгаа юм. Салбарын суурь хуулиудын нэмэлт өөрчлөлтийн дагуу зохицуулалтын баримт бичгийг нийцүүлэн шинэчлэх,



нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус хуралдаанд “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай танилцуулга, тогтоолын төсөл, баримт бичгийн төслийг боловсруулан хэлэлцүүлэв. Хуралдаанаас Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 9.1.3 дах заалтыг тус тус үндэслэн “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг шинэчлэн батлах тухай” 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 35 тоот тогтоолыг хавсралтын хамт батлав. Уг баримт бичиг батлагдснаар хот суурин, барилга байгууламж хооронд холбооны худаг, сувагчлал, шилэн болон зэс кабель шугам, агаарын шугам угсарч, суурилуулах; барилгын дотор холбооны сувагчлал, сүлжээ байгуулж, тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалт, холболтын ажил үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл; харин холбооны цамхаг байгуулж, түүн дээр холбооны тоног төхөөрөмж угсарч суурилуулах ажил үйлчилгээ эрхлэх бол тусгай зөвшөөрөлд нэмэлт хийлгэх; зөвхөн барилгын дотор холбооны сувагчлал, сүлжээ байгуулж, тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалт, холболт хийх ажил үйлчилгээ эрхлэх тохиолдолд Харилцаа холбооны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт заасны дагуу Зохицуулах хороонд бүртгүүлж, гэрчилгээ олгох; тусгай зөвшөөрөл олгоход тавигдах техник хэрэгсэл, хүний нөөц, үйл ажиллагаандаа мөрдөх шинэчлэгдсэн стандарт зэрэг зохицуулалтыг нэмэлтээр оруулж заасан байна. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2014 оны 10 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ыг хүчингүй болгов.

- Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны ээлжит 8 дугаар хуралдаанаар “Томоохон өртэй тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаарх танилцуулга, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай”, аудитын компаний зөвлөмж, хорооны хуралдааны тэмдэглэлийн төсөл, Даргын зөвлөлийн 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 02 тоот хуралдааны тэмдэглэл, тусгай зөвшөөрлийн талаар цаашид авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний саналыг тус тус авч хэлэлцээд, хорооны хуралдаанаас 2019 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн “Тусгай зөвшөөрлийн өр төлбөрийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 13 дугаар хуралдааны тэмдэглэлээр хугацаатай үүрэг даалгавар, удирдамж чиглэлийг өгч, холбогдох арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжүүлэн ажиллахыг Дэд дарга, Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газарт тус тус үүрэг болгосон. Энэхүү тэмдэглэлийн дагуу “Хорооны хуралдааны 2019 оны 13 дугаар тэмдэглэлийн хэрэгжилт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналын тухай” хэрэгжүүлсэн арга хэмжээ, хэрэгжилтийн танилцуулгыг хорооны хуралдаанд танилцуулан хуралдааны тэмдэглэлийн 1 дүгээр заалт бүрэн хэрэгжсэн, тэмдэглэлийн 2 дугаар хэсэгт заасан Жи-Мобайл ХХК-ийн үлдэгдэл өр төлбөрийг үе шаттай барагдуулах, төлүүлэх хуваарийг гаргах, хэрэгжилтийг зохион байгуулах, хорооны хуралдаанд тухай бүр танилцуулахыг Дэд дарга, холбогдох газар хэлтэст үүрэг болгов.
- ХХЗХ-ны 2017 оны ээлжит 12 дугаар хуралдаанаар “Радио өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх талаар цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал”-ын тухай танилцуулгыг хэлэлцэж, ХХМТГ-ын 2017 А/71 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Монгол Улсад радио өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэхэд баримтлах чиглэл” -ийн 6.6 заалтыг “...тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг шинээр боловсруулж, олгох ажлыг зохион байгуулна” гэсэн заалтыг хэрэгжүүлэхийг үүрэг болгосон. Энэхүү үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор хорооны Даргын 2018 оны А/14 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллаж, улмаар ажлын хэсгээс боловсруулан хорооны 2018 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар “Тоон радио өргөн нэвтрүүлгийн станцад ашилах радио давтамжийн зурвасын



хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага"-ыг батлуулсан бөгөөд Улаанбаатар хотод тоон радио өргөн нэвтрүүлгийн туршилтын сүлжээг байгуулах талаар хүсэлт гаргагч Эм Эс Жи Эм ХХК-иас ирүүлсэн санал, тусгай зөвшөөрлийн гэрээнд оруулах нөхцөл, шаардлагуудын төслийг тус хуралдаанд РДХЗГ, ЗБХГ-аас боловсруулан танилцуулсан. Хуралдаанаас Эм Эс Жи Эм ХХК-иас ирүүлсэн санал, гэрээнд тавигдах нөхцөл шаардлагын төслийг хэлэлцэн зарчмын хувьд дэмжиж, тус хуулийн этгээдэд Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт "Радиоогийн газрын дахин дамжуулах сүлжээ байгуулах, эзэмших, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх" болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт тоон радиоогийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд "Радио давтамж ашиглах" тусгай зөвшөөрлийг тус тус олгохоор 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн "Тусгай зөвшөөрөл олгох тухай" 36 дугаар тогтоолын хавсралтад оруулан шийдвэрлэв.

- Бусад асуудлын хүрээнд Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын үйл ажиллагаа, төсөв санхүү, ашиглалт үйлчилгээний байдал, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн талаар мэдээллийг сонсож, УИХ-аар батлуулах 2020 оны улсын төсөвт тус компаний холбогдох зардлыг тусгуулах талаар ХХМТГ, ХХЗХ-ноос бодлого, зохицуулалтын чиглэлээр дэмжлэг үзүүлж хамтран ажиллах нь зүйтэй гэж үзэв.
- Тус хорооны хуралдаанаар "Тусгай зөвшөөрөл олгох тухай", "Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай", "Тусгай зөвшөөрөл түдгэдзүүлэх тухай", "Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай" газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, дүгнэлт болон 4 тогтоолын төслийг авч хэлэлцэв. Энэхүү хэлэлцсэн асуудлаар 4 тогтоолыг батлан шийдвэрлэв:
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 9 хуулийн этгээдэд 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 36 тоот тогтоолын хавсралтаар 11 тусгай зөвшөөрөл шинээр олгосон;
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны баталсан "Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам"-ын 10.2 дах хэсгийг тус тус үндэслэн 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 37 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулсан;
 - Ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 38 дугаар тогтоолоор 1 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг 2 сарын хугацаагаар түдгэлзүүлсэн;
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дах заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны баталсан "Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам"-ын 12.1.1, 12.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 39 тоот тогтоолыг тус тус батлав.



11. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны ээлжит 10 дугаар хуралдааныг 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан бөгөөд энэхүү хуралдаанаар “Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн шаардлага, норматив”-ыг шинэчлэн батлах тухай; “Цахилгаан холбооны сүлжээний дугаар олгох журам”-ыг шинэчлэн батлах тухай; Баталгаажуулалтын үйл ажиллагааны 11 багц баримт бичгүүдийг шинэчлэн батлах тухай; Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай; ХХЗХ-ноос 2019 оны 10 сард зохион байгуулсан Зүүн бүсийн зөвлөгөөний тайлан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын тухай; Тусгай зөвшөөрлийн тухай; Бусад (“Харилцааны холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын эцсийн найруулгын танилцуулга, “Дэлхийн Радиогийн их хурал-2019”-д оролцох тухай танилцуулга) зэрэг 8 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн болно. Уг хуралдаан нь хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 7 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 1 тэмдэглэлээр хугацаатай үүрэг, даалгавар холбогдох газар, хэлтэсийн удирдлагад үүрэг болгосон.

- Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.2 заалтыг үндэслэл болгон Захиргааны эрх зүйн хэм хэмжээний акт баримт бичигт нийцүүлэх зорилгоор “Цахилгаан холбооны сүлжээний дугаар олгох журам”, “Тусгай дугаар ашигласан ярианы үйлчилгээний зохицуулалт”, “Тусгай дугаарт мессежний үйлчилгээний зохицуулалт”-ын баримт бичгүүдэд холбогдох боловсруулалт, найруулгыг хийж шинэчлэн боловсруулжээ. Үүнд: Дээрх 3 баримт бичгүүд нь дугаарлалтын зохицуулалтын үйл ажиллагаатай холбоотой бөгөөд нэгтгэн 2 хавсралт бүхий 1 баримт бичиг болгосон; бусад баримт бичигт давхардсан заалтыг хасч, уялдуулж найруулсан; найруулгын өөрчлөлт хийсэн; одоогийн хийж буй үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээний дугаарлалтын ашиглалт, төлвийн мэдээллийг шууд авч байх дугаарлалтын нэгдсэн системийн үйл ажиллагаатай холбоотой заалтууд нэмсэн; үйлчилгээ эрхлэгчид болон холбогдох төрийн байгууллагуудаас санал авч, ШӨХТГ-аас ирүүлсэн саналыг тусгасан; журмын хавсралтаар нэгтгэсэн 2 зохицуулалтын баримт бичгийн нэрийг нөхцөл, шаардлага болгон өөрчилж, нөхцөл болон тавигдах шаардлагуудыг ялгаж зүйл, заалтын дугаар, байрыг өөрчлөн илүү ойлгомжтой болгосон болно. Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газраас цахилгаан холбооны сүлжээний дугаар олгох зохицуулалтыг журамлах асуудлыг ЗЕХ, Харилцаа холбооны тухай хуульд нийцүүлж, шинэчлэн боловсруулсан танилцуулга, тогтоолын төсөл, хавсралт баримт бичгийн төслийг тус хуралдаанаар авч хэлэлцсэн ба энэхүү хуралдааны **2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 41 тоот “Журам шинэчлэн батлах тухай”** тогтоолыг батлаад байна. Энэхүү тогтоол, журмыг ХЗДХЯ-нд бүртгүүлэхээр хүргүүлэв.
- Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 42 тоот тогтоолын хавсралтаар “Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг батлан мөрдөж байна. ХЗДХЯ-наас албан тоотоор уг тогтоол, хавсралт баримт бичгийг ЗЕХ, Радио долгионы тухай, Харилцаа холбооны тухай хуульд нийцүүлэх талаар санал, зөвлөмж ирүүлсэн бөгөөд тус хорооны холбогдох газар, хэлтэс хамтран Захиргааны ерөнхий хууль, Радио долгионы тухай хууль, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулан “Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага” баримт бичгийн төслийг нийцүүлэн шинэчлэн боловсруулжээ. Тухайлбал, Хуульд нэмэлт оруулсан



Радио долгионы тухай хуулийн “5^{1.1.2}.радио давтамж, радио давтамжийн зурвасын хуваарилалт хийх, радио давтамжид баримтлах зохицуулалт, радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норматив баримт бичиг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих” заалтыг үндэслэл болгосон; улсын хэмжээнд тоон телевизийн өргөн нэвтрүүлэгт бүрэн шилжсэнтэй холбогдуулан 2013 оны 28 дугаар тогтоолоор баталсан аналог, тоон телевизийн өргөн нэвтрүүлэгт хуваарилсан сувгуудаас аналогий сувгийн хуваарилалтыг хассан; шинэчлэн боловсруулсан “Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн шаардлага, норматив”-д байгууллагын цахим хуудас болон Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын саналыг тус тус тусгасан; ХХЗХ-ны 2018 оны 33 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан “1.5 ба 2 ГГц давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн шаардлага” хавсралтыг нэгтгэн хавсралтаар оруулсан болно. Тус хуралдаанаар “Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн шаардлага, норматив”-ыг батлах тухай танилцуулга, тогтоолын төсөл, хавсралт баримт бичгийн төслийг авч хэлэлцээд, Радио долгионы тухай хуулийн 5^{1.1.2} дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.2 дах хэсгийг тус тус үндэслэн “Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн шаардлага, норматив”-ыг шинэчлэн батлах тухай **2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 42 тоот тогтоолыг батлан шийдвэрлэв.** Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2013 оны 28 тоот, 2017 оны 42 тоот тогтоол, 2018 оны 33 тоот тогтоолыг тус тус хүчингүй болгов. Энэхүү баримт бичиг батлагдснаар Дэлхийн Радиогийн их хурлаас баталсан Олон улсын радио давтамжийн дүрэм болон Монгол улсын “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-ийн заалтуудыг үндэслэн телевизийн өргөн нэвтрүүлгийн (ТӨН) станцад ашиглах радио давтамжийн зурвасыг хуваарилах, радио давтамжийг үр дүнтэй ашиглах техникийн шаардлага, нормативыг шинэчлэн тогоож, хорооны зүгээс хэрэгжилтийг хангуулах, зохион байгуулах, хяналт тавих зэрэг ач холбогдолтой юм.

- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дах заалт болон Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн хорооны 2019 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам батлах тухай” 29 дугаар тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар “Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам”-ыг шинэчилсэн болно. Энэхүү тогтоолыг ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн 4417 тоот улсын бүртгэлд 2019 оны 9 дүгээр сард бүртгүүлэн баталгаажуулсан юм. Улмаар, зохицуулах хорооны 2013 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Баталгаажуулалтын хяналтын журам, Чанарын гарын авлага зэрэг 11 баримт бичгийг 2018 онд шинэчлэн баталсан “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хууль, “Харилцаа холбооны тухай” хуулийн 9.1.3-д заасан харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийг баталгаажуулах, холбогдох техникийн нөхцөл, шаардлага, норматив баримт бичиг, журмууд болон баталгаажуулалт, итгэмжлэлийн үндэсний стандартуудад (MNS ISO/IEC 17021:2008, MNS ISO IEC 17065:2013, MNS ISO/IEC 17065:2015, MNS ISO 9000:2017 г.м) нийцүүлэн шинэчлэх шаардлага гарсан юм. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд РДХЗГ, ЗУХАГ-аас хамтран боловсруулж “Баталгаажуулалтын үйл ажиллагааны журмуудыг шинэчлэн батлах тухай” танилцуулга, тогтоолын төсөл, баталгаажуулалтын дотоод үйл ажиллагаанд мөрдөх 11 дүрэм, журмуудын төслийг тус хорооны хуралдаанд хэлэлцүүлэв. Хорооны хуралдааны “Баталгаажуулалтын үйл ажиллагааны журмуудыг шинэчлэн батлах тухай” **2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 43 тоот тогтоолыг 11 баримт бичиг, журам бүхий хавсралтын хамт** Харилцаа холбооны тухай хуулийн



9 дүгээр зүйлийн 9.1.3 дах хэсгийг үндэслэн батлав. Тогтоолд зааснаар, “Баримт бичгийн хяналтын журам”-ыг энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралтаар, “Бүртгэл хөтлөх, нэвтрэх, хадгалах, устгах журам”-ыг Хоёрдугаар хавсралтаар, “Дотоод аудит, хяналт мониторингийн журам”-ыг Гуравдугаар хавсралтаар, “Удирдлагын дүн шинжилгээ хийх журам”-ыг Дөрөвдүгээр хавсралтаар, “Тохирлын гэрчилгээ олгох, хадгалах, хугацаа сунгах, цуцлах журам”-ыг Тавдугаар хавсралтаар, “Баталгаажуулалтын явцад олж авсан мэдээллийн нууцлаг байдлыг хадгалах журам”-ыг Зургаадугаар хавсралтаар, “Баталгаажуулалтын үйл ажиллагаатай холбоотой гарсан өргөдөл, гомдол, маргаан шийдвэрлэх журам”-ыг Долоодугаар хавсралтаар, “Үл тохирлыг шийдвэрлэх болон аливаа залруулах, сэргийлэх талаар авсан арга хэмжээний үр нөлөөг хангах журам”-ыг Наймдугаар хавсралтаар, “Хүлээн зөвшөөрсөн хавсран гүйцэтгэгчийн ур чадварыг үнэлж бүртгэх, хамтран ажиллах, ажиглалт хийх журам”-ыг Есдүгээр хавсралтаар, “Мэдээлэл, харилцаа холбооны баталгаажсан тоног төхөөрөмжид тохирлын тэмдэг олгох журам”-ыг Аравдугаар хавсралтаар, “Чанарын гарын авлага”-ыг Арваннэгдүгээр хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсан байна. Түүнчлэн Баталгаажуулалтын зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн дүрмийг батлахыг Хорооны дарга-д зөвшөөрөв. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2013 оны 27 тоот тогтоол, 2014 оны 19 тоот тогтоол, 2014 оны 43 тоот тогтоол, 2016 оны 46 тоот тогтоолыг тус тус хүчингүй болгожээ.

- Харилцаа холбооны зохицуулах хороо нь “Харилцаа холбооны тухай” хуулийн 9.1.11 болон тус хуулийн 6.1.4-д заасан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны А/42 тоот тушаалаар батлагдсан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам”-ыг үндэслэн Зохицуулах хорооны 2017 оны 58 тоот тогтоолоор “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-г шинэчлэн баталж, ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2017 оны 3824 дугаарт бүртгүүлэн мөрдөж байна. Тус хуралдаанаар шинэ үйлчилгээ болох Улаанбаатар хотод “Тоон радио өргөн нэвтрүүлгийн газрын дамжуулах сүлжээ байгуулах, үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөлтэй холбогдуулан боловсруулсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-нд нэмэлт оруулах тухай танилцуулга, хорооны тогтоолын төслийг хэлэлцэв. Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.11, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны А/42 тоот тушаалаар баталсан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам”-ыг тус тус үндэслэн Зохицуулах хорооны “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн батлах тухай” 2017 оны 58 дугаар тогтоолын “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-нд 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 44 тоот тогтоолоор нэмэлт оруулан батлав. Энэхүү тогтоолд оруулсан нэмэлтийг ХЗДХЯ-нд бүртгүүлэхээр хүргүүлэх болно.
- Тус хорооны хуралдаанаар “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, дүгнэлт болон 3 тогтоолын төслийг авч хэлэлцэв. Энэхүү хэлэлцсэн асуудлаар 3 тогтоолыг батлан шийдвэрлэв:
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 17 хуулийн этгээдэд 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 45 тоот тогтоолын хавсралтаар 17 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;



- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 10.1, 10.2 дэх хэсэг, 10.3.3 дэх заалтыг тус тус үндэслэн 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 46 тоот тогтоолоор 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулсан;
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 12.1.1 дэх заалт болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өөрийн хүсэлтийг тус тус үндэслэн 1 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 47 тоот тогтоолыг тус тус батлав.
- Хуралдаанаар хэлэлцсэн бусад асуудлаар, “Харилцааны холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын эцсийн найруулгын танилцуулга; ХХЗХ-ноос 2019 оны 10 сард зохион байгуулсан Зүүн бүсийн зөвлөгөөний тайлан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын тухай; “Дэлхийн Радиогийн их хурал-2019”-д оролцох тухай танилцуулгыг хариуцсан газар, хэлтэсээс хорооны хуралдаанд танилцуулга, мэдээлэл хийлээ.

12. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны ээлжит 11 дүгээр хуралдаан 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр болов. Уг хуралдаанаар Шуудангийн зохицуулалтын баримт бичгүүдийг хууль, тогтоомжид нийцүүлэх, шинэчлэн батлах тухай (“Шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл шаардлага”; “Шуудангийн үйлчилгээ эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”; “Шуудангийн харилцан холболтын журам”); “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны үйл ажиллагааны төсвийн төлөвлөгөөний төсөл”-ийн талаар танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай; Бусад (Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам”-ын эцсийн найруулгын танилцуулга) зэрэг 4 асуудлыг хэлэлцэн хорооны тогтоол, тэмдэглэлийг баталсан болно. Уг хуралдаан нь хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 4 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 2 тэмдэглэлээр хугацаатай үүрэг, даалгавар холбогдох газар, хэлтсийн удирдлагад даалгасан.

- Шуудангийн зохицуулалтын газар, Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газраас хамтран боловсруулсан шуудангийн зохицуулалтын баримт бичгүүдийг хууль, тогтоомжид нийцүүлэх, шинэчлэн батлах тухай (“Шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл шаардлага”; “Шуудангийн үйлчилгээ эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”; “Шуудангийн харилцан холболтын журам”) танилцуулга, нөхцөл шаардлага болон журмын төслүүд, тогтоолын төслийг хорооны 2019 оны ээлжит 11 дүгээр хуралдаанд хэлэлцүүлэв. Хэлэлцсэн асуудлаар, хорооны 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит 11 дүгээр хуралдааны “Шуудангийн зохицуулалтын талаар авах арга хэмжээний тухай” 16 дугаар хуралдааны тэмдэглэлийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар болон удирдамж, чиглэлийг Шуудангийн зохицуулалтын газар, Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газарт тус тус өгч үүрэг болгов. Энэхүү хуралдааны тэмдэглэлийн 1 дүгээр заалтаар, хуралдааны үеэр хорооны гишүүдээс гаргасан дээрх 3 баримт бичгийн төслүүдийн холбогдох заалтыг ХХМТГ-ын баримталж байгаа шуудангийн бодлого, дүрэм журамтай уялдуулах, хуулийн хэллэг ба зарчимд нийцүүлэх; формат



загварын дагуу шуудангийн сүлжээ, үйлчилгээ, харилцан холболтын болон шуудангийн үйлчилгээ эрхлэгчдэд тавих нөхцөл, шаардлагыг хялбаршуулах, гэрээний бүртгэл хяналт, хаягжилт, үндэсний стандарттай уялдуулах асуудлыг судалж нийтээр дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн дахин боловсруулж, баримт бичгийн эцсийн найруулгыг Хорооны дараагийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж тогтов. Хоёрдугаар заалтаар, Хуралдааны явцад хорооны дарга Г.Чинзоригоос шуудангийн салбарт Харилцаа холбооны тухай хууль, Шуудангийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал, шуудангийн үйлчилгээ эрхлэгч нараас гаргаж байгаа зөрчил дутагдал, хууль зөрчсөн /хар тамхи, мансууруулах бодис, хориотой бараа г.м/ үйл ажиллагаа, хэрэг үүсгэсэн жагсаалт, мэдээллийн асуудлаар холбогдох хууль хяналт, прокурор, гааль, мэргэжлийн хяналтын байгууллага, гэмт хэрэг хариуцсан прокурортой Шуудангийн зохицуулалтын газрын удирдлага, шуудангийн Улсын байцаагч нар биечлэн уулзаж, хамтын ажиллагаа, оролцоогоо сайжруулах, албан ёсоор жагсаалт мэдээлэл, тайланг авч нэгтгэн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт боловсруулж, Хорооны 2019 оны ээлжит 12 дугаар хуралдаанд танилцуулахыг Шуудангийн зохицуулалтын газарт үүрэг болгов.

- Хорооны ээлжит хуралдаанаар Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газраас нэгтгэн боловсруулсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны үйл ажиллагааны төсвийн төлөвлөгөөний төсөл”-ийн талаар танилцуулга, мэдээллийг авч хэлэлцэж, хуралдааны үеэр хорооны дарга, гишүүдээс өгсөн үүрэг даалгавар, удирдамж чиглэлийг үндэслэн хорооны 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 17 дугаар “ХХЗХ-ны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн төслийн талаар удирдамж, чиглэл өгөх тухай” тэмдэглэлийг баталсан болно. Энэхүү хуралдааны тэмдэглэлийн хавсралтад заасан удирдамж, чиглэл болон үүрэг даалгаврыг хорооны Дэд дарга, газар хэлтсийн дарга, ерөнхий нягтлан, ахлах мэргэжилтэн нарт өгөхөөр тогтов. Хуралдааны тэмдэглэлийн хавсралтад заасан удирдамж чиглэл, үүрэг даалгаврыг 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн төлөвлөгөөний төслийн баримт бичигт тусгах асуудлыг судлан боловсруулж, Хорооны дараагийн ээлжит хуралдаанд хэлэлцүүлэхийг Дэд дарга, Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газарт тус тус үүрэг болгов. Тэмдэглэлийн гуравдугаар заалтаар, хорооны хуралдааны тэмдэглэлээр болон хуралдааны явцад хорооны дарга, гишүүдээс өгсөн санал, зөвлөмж болон хуралдаанаас өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийн тайланг 2019 онд багтаан Хорооны дарга, гишүүдэд хүргүүлэн хуралдаанд танилцуулахыг Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга-д даалгав.
- Хуралдаанаар хэлэлцсэн бусад асуудлаар, “Харилцааны холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын эцсийн найруулгын танилцуулгыг хийж, өгөгдсөн удирдамж чиглэлийг тусгасан байна гэж үзэв.
- Тус хорооны хуралдаанаар “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай”, “Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, дүгнэлт болон 4 тогтоолын төслийг авч хэлэлцэв. Энэхүү хэлэлцсэн асуудлаар 4 тогтоолыг батлан шийдвэрлэв:
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн



8 хуулийн этгээдэд 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 48 тоот тогтоолын хавсралтаар 8 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 10.2 дах хэсгийг тус тус үндэслэн 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 49 тоот тогтоолоор 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулсан;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 50 тоот тогтоолоор 4 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсэн;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дах заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 12.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 3 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 51 тоот тогтоолыг тус тус батлав.

13. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны ээлжит 12 дугаар хуралдааныг 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан бөгөөд энэхүү хуралдаанаар “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн төсөл”-ийн тухай; Шуудангийн зохицуулалтын баримт бичгүүдийг хууль, тогтоомжид нийцүүлэх, шинэчлэн батлах тухай (*“Шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл шаардлага”*; *“Шуудангийн үйлчилгээ эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”*; *“Шуудангийн харилцан холболтын журам”-ын эцсийн найруулгын танилцуулга*); “Радио төхөөрөмж ажиллуулах, үйл ажиллагааг нь зогсоох, хориглох журам”-ын төсөл; Ажлын хэсгийн шалгалтын тайлан ба дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналын тухай; Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасч, актлах тухай; Хорооны дансны авлагад залруулга хийх талаар танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай; Бусад (Хорооны 2019 оны ээлжит 11 дүгээр хуралдаанаас гаргасан 16 дугаар хуралдааны тэмдэглэлийн 2 дугаар заалтын хэрэгжилтийн танилцуулга) нийтдээ зэрэг 8 асуудлыг хэлэлцэн хорооны тогтоол, тэмдэглэлийг батлан шийдвэрлэсэн. Энэхүү хуралдаан нь хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 8 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 2 тэмдэглэлээр хугацаатай үүрэг, даалгавар болон удирдамж, чиглэлийг холбогдох газар, хэлтсийн удирдлагад үүрэг болгов.

- Хорооны 2019 оны ээлжит 11 дүгээр хуралдаанаар Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газраас нэгтгэн боловсруулсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны үйл ажиллагааны төсвийн төлөвлөгөөний төсөл”-ийн талаар танилцуулга, мэдээллийг авч хэлэлцэж, хуралдааны үеэр хорооны дарга, гишүүдээс өгсөн үүрэг даалгавар, удирдамж чиглэлийг үндэслэн хорооны 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 17 дугаар “ХХЗХ-ны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн төслийн талаар удирдамж, чиглэл өгөх тухай” тэмдэглэлийг баталсан.



- Энэхүү тэмдэглэлийн хавсралтаар хуралдааны үеэр дарга, гишүүдээс өгсөн удирдамж чиглэл, үүрэг даалгаврыг тусган боловсруулж, хорооны 2019 оны ээлжит 12 дугаар хуралдаанд хэлэлцүүлэв. Тус хуралдаанаас “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны үйл ажиллагааны төсвийн төлөвлөгөөний төсөл”-ийг зарчмын хувьд дэмжиж, ажлын шугамаар зарим нэмэлт санал, зөвлөмжийг тусган эцсийн найруулгыг гишүүдэд танилцуулан батлахаар тогтов.
- Зохицуулах хорооны 2019 оны ээлжит 11 дүгээр хуралдааны “Шуудангийн зохицуулалтын талаар авах арга хэмжээний тухай” 16 дугаар хуралдааны тэмдэглэлийн 1 дүгээр заалтаар өгөгдсөн удирдамж, чиглэл болон үүрэг, даалгаврын дагуу Шуудангийн зохицуулалтын баримт бичгүүдийг хууль, тогтоомжид нийцүүлэх, шинэчлэн батлах тухай (“Шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл шаардлага”; “Шуудангийн үйлчилгээ эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”; “Шуудангийн харилцан холболтын журам”-ын эцсийн найруулгын танилцуулга) танилцуулга, тогтоолын төсөл, хавсралт нөхцөл шаардлага ба журамын төслийг хэлэлцээд, ээлжит 11 дүгээр хуралдаанаас өгсөн удирдамж, чиглэлийг тусган боловсруулсан байна гэж үзэв. Ийнхүү тус хуралдаанаар Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх, 9.1.6 дах заалтыг тус тус үндэслэн “Шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл, шаардлагыг шинэчлэн батлах тухай” 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 52 тоот тогтоолыг батлахаар шийдвэрлэж, энэхүү тогтоолын хавсралтаар “Шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэн батлав. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Харилцаа холбооны зохицуулах хорооны 2013 оны 64 тоот тогтоолын 1 дүгээр хавсралт, 2016 оны 12 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтын холбогдох хэсгийг тус тус хүчингүй болголоо. Уг тогтоолыг баталснаар “Шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл, шаардлага” болгон нөхцөл, шаардлагын хуучин нэрийг Шуудангийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлсэн; шуудангийн сүлжээг байгуулах, түүнийг ашиглахад тавигдах ерөнхий шалгуур шаардлагуудыг нэгтгэж, шуудангийн сүлжээний ангилалд нийцүүлэн холбогдох өөрчлөлтийг оруулсан, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд шуудангийн сүлжээ байгуулахад давхардуулсан хүндрэл үүсгэхгүй байх зарчмыг тодорхойлсон байна.
 - Хуралдаанаас Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх, 9.1.6 дах заалтыг тус тус үндэслэн хорооны 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 53 тоот “Шуудангийн үйлчилгээ эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг шинэчлэн батлах тухай” тогтоолыг хавсралтын хамт баталснаар тус хорооны 2015 оны 13 тоот тогтоолыг хүчингүй болгов. Энэхүү нөхцөл, шаардлагад хуучин нэрийг Шуудангийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн, шуудангийн үйлчилгээ эрхлэхэд тавигдах ерөнхий шалгуур шаардлагуудыг нэгтгэж, үнэ тариф, үйлчилгээ, ажлын байр, үйлчилгээний техникийн нөхцөл гэж ангилснаас гадна шуудангийн үйлчилгээний төрөл ангилалд нийцүүлэн холбогдох өөрчлөлтийг тусган баталжээ.
 - Улсын Их хурлаас 2019 онд батлагдсан Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 9.1.5 дах заалтаар тус хороо нь шуудангийн харилцан холболтын журмыг баталж, хэрэгжилтийг хангуулах бүрэн эрхтэй болсон юм. Тус хорооны 2019 оны ээлжит 12 дугаар хуралдаанаас Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дах заалтыг үндэслэн “Шуудангийн харилцан холболтын журам”-ыг хорооны 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 54 тоот тогтоолын хавсралт ёсоор шинэчлэн баталсан. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2017 оны 16 тоот тогтоолыг хүчингүй болгов. Шуудангийн харилцан холболтын үндсэн зарчим, чиглэлийг журмаар шинэчлэн тогтоохдоо шуудангийн үндсэн сүлжээ, шуудангаар үйлчлэгч, мөн шуудангаар үйлчлэгч хоорондоо харилцан холбогдох нөхцлийг бүрдүүлэх, улс хоорондын шуудангийн илгээмжийг үндсэн сүлжээгээр бус өөр сүлжээгээр дамжуулан Монгол улсын нутаг дэвсгэрт хүргэх



нөхцлийг бүрдүүлэх, дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэгчид улс хоорондын шуудангийн илгээмжийг хүлээн авч улс хоорондын үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дамжуулан хүргэх нөхцлийг бүрдүүлж байгаа болно. Шуудангийн харилцан холболтын журам нь шуудангаар үйлчилгээ эрхлэгчдэд үйлчилгээний алдагдлыг бууруулах, орлого хуваарилахдаа өртөгт суурилах зарчмыг хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

- УИХ-аас Радио долгионы тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан /2019-05-30/ баталснаар хуулийн “20.6.Радио төхөөрөмж ажиллуулах, үйл ажиллагааг нь зогсоох, хориглох журмыг Зохицуулах хороо баталж, мөрдүүлнэ.” гэж заасан болно. Уг заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ХХЗХ-ны Даргын 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/240 тоот тушааар “Радио төхөөрөмж ажиллуулах, үйл ажиллагааг нь зогсоох, хориглох журам”-ын төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг, РДХЗГ, ЗУХАГ-аас хамтран боловсруулж хорооны 2019 оны ээлжит 12 дугаар хуралдаанд “Радио төхөөрөмж ажиллуулах, үйл ажиллагааг нь зогсоох, хориглох журам”-ын танилцуулга, журмын төсөл, тогтоолын төслийг тус тус авч хэлэлцүүлэв. Зохицуулах хорооны уг хуралдаанаас Радио долгионы тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дах хэсэгт заасныг үндэслэн 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Журам батлах тухай” 55 тоот тогтоолыг “Радио төхөөрөмж ажиллуулах, үйл ажиллагааг нь зогсоох, хориглох журам”-ын хавсралтын хамт батлав. Энэхүү журам нь Харилцаа Холбооны тухай хууль, Радио долгионы тухай хуулийн хүрээнд радио төхөөрөмж ажиллуулах, ашиглах, үйл ажиллагааг нь зогсоох, хориглохтой холбогдсон харилцааг зохицуулна. Радио долгионы хяналт шалгалт, хэмжилтийг гүйцэтгэхэд ХХЗХ, СХЗГ, МХЕГ-аас Монгол Улсын болон ОУЦХБ-аас баталдсан радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага, холбогдох үндэсний стандарт, арга аргачилал, зөвлөмжийг баримтлахаар оруулжээ.
- Зохицуулах хорооны Даргын 2019 оны А/284 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн удирдамжийн дагуу хийсэн гүйцэтгэлийн хяналт, шалгалтын “Ажлын хэсгийн шалгалтын тайлан ба дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналын тухай” болон ШЗГ-аас боловсруулсан танилцуулга, тайлан мэдээлэл болон холбогдох хорооны хуралдааны тэмдэглэлийн төслийг тус тус хэлэлцээд, тусгай зөвшөөрлийг түр хугацаагаар түдгэлзүүлсэн Масс Ти Ви ХХК, Оргил медиа консалтинг ХХК, Маст технологи ХХК, Модерн Кастл Модифаер ХХК, Амех экспресс карго ХХК, Дөлгөөн дэлгэрэх ХХК зэрэг хуулийн этгээдүүд нараас заасан хугацаанд зөрчлийг арилган, үүрэг даалгаврын биелэлтийг хангасан байна гэж үзэж эдгээр 6 хуулийн этгээдийн “Тусгай зөвшөөрлийг сэргээх тухай” хуралдааны тогтоол гаргахаар шийдвэрлэж, тус хорооны хуралдааны 2019 оны 19 дүгээр тэмдэглэлийг гаргалаа.
- Энэхүү хуралдаанаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам болон тус Хорооны техникийн комиссын 2019 оны 11 дугаар сарын 15-ны өдрийн 15-2019, 16-2019 тоот акт, дүгнэлтийг тус тус үндэслэн “Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасч, актлах тухай” 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 56 тоот тогтоолыг батлав. Уг тогтоолд, тус хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 21-28 УНҮ улсын дугаартай Киа Спортэйж болон 00-98 УБН улсын дугаартай Тоёота Ланд Круйзер 105 маркийн 2 автомашины ашиглалтын хугацаа дуусч, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ балансын үнээ нөхсөн, сэргээн засварлахад өртөг өндөртэй, цаашид байгууллагын хэвийн үйл ажиллагаанд ашиглах боломжгүй болсон тул эдгээр 2 автомашиныг ашиглалтаас хасч, актлах саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэхээр тогтов.
- Зохицуулах хорооны 2019 оны ээлжит 12 дугаар хуралдаанд ЗУХАГ-аас “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний ажлын



хүрээнд боловсруулсан “ХХЗХ-ны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дансны авлагад залруулга хийх тухай” танилцуулга, хуралдааны тэмдэглэл, хавсралтын төслийг хэлэлцэв. Энэхүү асуудлаар, тус хуралдааны 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Дансны авлагын талаар авах арга хэмжээний тухай” 18 дугаар хуралдааны тэмдэглэл гаргахаар шийдвэрлэв. Тэмдэглэлд, Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газарт дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг даалгав. Үүнд: хуралдааны тэмдэглэлийн 1 дүгээр хавсралтад заасан “2019 оны дансны авлагын дүнгээс хасч залруулсан тусгай зөвшөөрлийн жагсаалт”-д заасан нэр бүхий 29 иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлийн нийт 432,223,697.66 төгрөгийн нэг эзэмшигчтэй зөвшөөрөл хооронд илүү төлөлтийг нь нөгөө зөвшөөрлийн төлбөрт шилжүүлэн тооцох, програмын бодолтоос шалтгаалж нэмэлт төлбөр тооцоолж байгааг хасч залруулах, тодорхойгүй орлогоос хаасан, тооцооны залруулга, эхний жилийн төлбөрөөс чөлөөлөх бүхий авлагуудыг тухайн тайлант жилийн авлагаар тооцсон дүнгээс буцаах залруулга хийх арга хэмжээг авах; хавсралтад заасан тусгай зөвшөөрлийн жагсаалтын дагуу авлагыг залруулан тайлагнах арга хэмжээ авах зэрэг болно.

- Хуралдаанаар хэлэлцсэн бусад асуудлаар, хорооны 2019 оны ээлжит 11 дүгээр хуралдааны “Шуудангийн зохицуулалтын талаар авах арга хэмжээний тухай” 16 дугаар хуралдааны тэмдэглэлийн 2 дугаар заалтаар өгсөн үүрэг, чиглэлийн дагуу шуудангийн салбарт Харилцаа холбооны тухай хууль, Шуудангийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал, шуудангийн үйлчилгээ эрхлэгч нараас гаргаж байгаа зөрчил дутагдал, хууль зөрчсөн /хар тамхи, мансууруулах бодис, хориотой бараа г.м/ үйл ажиллагаа, хэрэг үүсгэсэн жагсаалт, мэдээллийг ГЕГ, ЦЕГ, хариуцсан прокуророос албан тоотоор авч холбогдох танилцуулга, цаашид авах арга хэмжээний саналын талаар хорооны 2019 оны ээлжит 12 дугаар хуралдаанд ШЗГ-аас танилцуулга, мэдээлэл хийлээ.
- Тус хорооны хуралдаанаар “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай”, “Тусгай зөвшөөрөл сэргээх тухай” газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээ дүгнэлт болон 3 тогтоолын төслийг авч хэлэлцээд, хуралдааны 3 тогтоолыг батлан шийдвэрлэсэн:
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 9 хуулийн этгээдэд 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 57 тоот тогтоолын хавсралтаар 11 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 10.2 дах хэсгийг тус тус үндэслэн 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 58 тоот тогтоолоор 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулсан;
 - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дах заалт, 13 дугаар зүйлийн 13.3 дах хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалтыг тус тус үндэслэн 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 59 тоот тогтоолоор 6 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг сэргээсэн болно.



14. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны ээлжит бус 02 дугаар хуралдааныг 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж, ээлжит бус хуралдаанаар “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн төсөл”-ийн тухай (эцсийн найруулгын төсөл); Тусгай зөвшөөрлийн эрхийн төлбөрийн тухай; Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай; Бусад (Хорооны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд авлагад залруулга хийх талаар танилцуулга, хуралдааны тэмдэглэлийн төсөл; Тогтоолын холбогдох хэсгийг цуцлах тухай) зэрэг нийтдээ 5 асуудлыг хэлэлцэн хорооны тогтоол, тэмдэглэлийг батлан шийдвэрлэв. Уг хуралдаан нь хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 3 тогтоолыг баталж, хорооны хуралдааны 1 тэмдэглэлээр хугацаатай үүрэг, даалгавар болон удирдамж, чиглэлийг холбогдох газар, хэлтсийн удирдлагад даалгав.

➤ Зохицуулах хорооны 2019 оны ээлжит 12 дугаар хуралдаанаас “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны үйл ажиллагааны төсвийн төлөвлөгөөний төсөл”-ийг зарчмын хувьд дэмжиж, ажлын шугамаар зарим нэмэлт санал, зөвлөмжийг тусган эцсийн найруулгыг гишүүдэд танилцуулан батлахаар шийдвэрлэсэн юм. Энэхүү шийдвэрийн дагуу хорооны дарга, гишүүдээс өгсөн чиглэл, зөвлөмж болон гарсан саналыг тусган “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн төсөл”-ийн тухай (эцсийн найруулгын төсөл) боловсруулж, тус хорооны 2019 оны ээлжит бус 02 дугаар хуралдаанд хэлэлцүүлсэн болно. Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.16 дах заалт, Засгийн газрын 2016 оны 268 тоот тогтоолоор баталсан Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 2.1.2 дах заалтыг тус тус үндэслэн 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит бус 02 дугаар хуралдааны “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлогын төлөвлөгөө, зардал, 2021-2022 оны төсвийн төсөөллийг батлах тухай” 60 дугаар тогтоолыг баталсан. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-ны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”, 2 дугаар хавсралтаар “ХХЗХ-ны 2020 оны орлогын төлөвлөгөө”, 3 дугаар хавсралтаар “ХХЗХ-ны 2020 оны зардлын төлөвлөгөө”, 4 дүгээр хавсралтаар “ХХЗХ-ны 2020 оны хөрөнгө оруулалтын зардал”, 5 дугаар хавсралтаар “ХХЗХ-ны 2020 оны хөтөлбөр, арга хэмжээний зардал”, 6 дугаар хавсралтаар “ХХЗХ-ны 2020 оны үйл ажиллагааны зардал”, 7 дугаар хавсралтаар “ХХЗХ-ны 2021-2022 оны төсвийн төсөөлөл”-ийг тус тус батлав. Уг тогтоолын хавсралтаар баталсан Хорооны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, батлагдсан зардал төсвийг зориулалтын дагуу зарцуулан тухай бүр гүйцэтгэлийг тайлагнан ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д даалгав.

➤ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 20.2.20 заалт болон “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний ажлын хүрээнд “Жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдэх залруулгын тухай” танилцуулга, хуралдааны тэмдэглэлийн төсөл, хавсралт жагсаалтыг ЗУХАГ-аас боловсруулан тус хуралдаанд хэлэлцүүлэв. Энэхүү хэлэлцсэн асуудлаар, тус хуралдааны 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Дансны авлагын талаар авах арга хэмжээний тухай” 20 дугаар хуралдааны тэмдэглэл гаргахаар шийдвэрлэв. Уг хуралдааны тэмдэглэлд, Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газарт дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг даалгав. Үүнд: Хорооны энэхүү хуралдааны тэмдэглэлийн хавсралтад заасан “2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дансны авлагад залруулга хийх тусгай зөвшөөрлийн жагсаалт”-д заасан нэр бүхий иргэн, хуулийн этгээдийн 122 тусгай зөвшөөрлийн нийт 72,2 сая төгрөгийн нэг эзэмшигчтэй зөвшөөрөл хооронд илүү төлөлтийг нь нөгөө зөвшөөрлийн төлбөрт шилжүүлэн тооцох, програмын бодолтоос



шалтгаалж нэмэлт төлбөр тооцоолж байгааг хасч залруулах, тодорхойгүй орлогоос хаасан, тооцооны залруулга, эхний жилийн төлбөрөөс чөлөөлөх бүхий авлагуудыг тухайн тайлант жилийн авлагаар тооцсон дүнгээс буцаах залруулга хийх арга хэмжээг авах; энэхүү хуралдааны тэмдэглэлийн хавсралтад заасан тусгай зөвшөөрлийн жагсаалтын дагуу авлагыг залруулан тайлагнах арга хэмжээ авах зэрэг болно.

- Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газраас “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 11 дүгээр зүйлийн 11.1.3 дах заалт (заасан хугацаанд тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг, бүртгэлийн гэрчилгээний төлбөрөө төлөөгүй бол 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно)-ыг зөрчсөн; 2019 онд өр төлбөрийг барагдуулах тухай албан тоот, нэхэмжлэхийн хамт удаа дараа илгээсэн боловч өр төлбөрөө төлөөгүй; өр төлбөрөө төлөх тухай гэрээний үүргийг сануулж удаа дараа албан телефон утсаар мэдэгдсэн; төлбөрийн үлдэгдэлтэй зөвшөөрөл эзэмшигчид рүү тусгай дугаараас өр төлбөрөө төлөхийг сануулж мессеж илгээсэн боловч дээр заасан журам, нөхцөл шаардлагыг биелүүлээгүй, өр төлбөрийн үлдэгдлийг заасан хугацаанд барагдуулаагүй нэр бүхий 63 иргэн, хуулийн этгээдийн 89 тусгай зөвшөөрлийг 3 сараар түдгэлзүүлэх талаар танилцуулга, хорооны хуралдааны тогтоолын төсөл, хавсралт жагсаалтын төслийг тус хуралдаанаар хэлэлцүүлэв. Энэхүү асуудлыг авч хэлэлцээд, тус хуралдаанаас Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 11 дүгээр зүйлийн 11.1.3 дэх заалтыг тус тус үндэслэн 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай” 61 тоот тогтоолыг хавсралтын хамт баталсан болно. Уг тогтоолыг баталснаар тогтоолын хавсралтад заасан өр төлбөрийн зөрчилтэй иргэн, хуулийн этгээд нар нь дүэм, журам биелүүлээгүй, нөхцөл шаардлагын зөрчил, холбогдох өр төлбөрөө түдгэлзүүлсэн хугацаанд барагдуулах, өр төлбөрийн асуудлаа шийдвэрлээгүй тохиолдолд цаашид тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг хорооны хуралдаанд тухай бүр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх арга хэмжээг авах болно.
- Хуралдааны хэлэлцсэн бусад асуудлаар, ЗУХАГ-аас 2018-2019 онд тусгай зөвшөөрөл олгох тогтоол, шийдвэр гарсан боловч тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулаагүй, зөвшөөрлийн төлбөрөө төлөөгүй, гэрчилгээгээ аваагүй нийт 14 иргэн, хуулийн этгээд нарын тусгай зөвшөөрлийг цуцлах саналын талаар танилцуулга, тогтоолын төслийг тус тус авч хэлэлцээд, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийг үндэслэн “Тогтоолын холбогдох хэсгийг цуцлах тухай” 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 62 тоот тогтоолыг батлахаар шийдвэрлэв. Уг тогтоол батлагдснаар, тус хорооны “Тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолоор тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэр гарсан боловч тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулаагүй, төлбөрийн зөрчилтэй, зөвшөөрлийн гэрчилгээгээ аваагүй 2019 оны 62 тоот тогтоолын хавсралтад заасан 14 нэр бүхий иргэн, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох тухай тогтоолын тухайн иргэн, хуулийн этгээдэд холбогдох хэсгийг цуцлахаар шийдвэрлэв. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрөл олгох тухай тогтоолын дагуу үүсгэсэн авлагыг залруулах арга хэмжээг зохион байгуулж шийдвэрлэх, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг холбогдох газар, хэлтэст даалгасан болно.



Хорооны хуралдаанаас 2019 онд баталсан тогтоол, шийдвэрийн жагсаалтыг тайлбарын хамт нэгтгэн дор үзүүлэв:

№	Хорооны баталсан тогтоол, тэмдэглэлийн дугаар	Огноо	Тогтоол, тэмдэглэлийн товч агуулга	Тайлбар
1	Тогтоол 01	2019.01.24	Баримт бичиг батлах тухай “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019-2024 оны үйл ажиллагааны стратеги”	
2	Тогтоол 02	2019.01.24	Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасч, актлах тухай	
3	Тогтоол 03	2019.01.24	Тусгай зөвшөөрөл олгох тухай	ТЗ шинээр олгосон: 8 хуулийн этгээдэд 8 тусгай зөвшөөрөл
4	Тогтоол 04	2019.01.24	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай	Хүчингүй болгосон: 2 хуулийн этгээдийн 3 тусгай зөвшөөрөл
5	Тогтоол 05	2019.01.24	“Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-нд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хүчингүй болгосон: 2008 оны 15 тоот тогтоол, 2012 оны 31 тоот тогтоол, 2015 оны 47 тоот тогтоол, 66 тоот тогтоол, 70 тоот тогтоолын хавсралтын 1 дүгээр хэсэг (5).
6	Тогтоол 06	2019.02.27	Тусгай зөвшөөрөл олгох тухай	ТЗ шинээр олгосон: 8 хуулийн этгээдэд 6 тусгай зөвшөөрөл
7	Тогтоол 07	2019.02.27	Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Өөрчлөлт оруулсан: 6 хуулийн этгээдийн 6 тусгай зөвшөөрөл
8	Тогтоол 08	2019.02.27	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай	Хүчингүй болгосон: 9 хуулийн этгээдийн 10 тусгай зөвшөөрөл
9	Тогтоол 09	2019.03.14	“Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (ХЗДХЯ, Хүлээн авсан)	Хүчингүй болгосон: 2004 оны 22 тоот тогтоол, 2011 оны 56 тоот тогтоол, 2015 оны 65 тоот тогтоол (3).
10	Тогтоол 10	2019.03.14	Тусгай зөвшөөрөл олгох тухай	ТЗ шинээр олгосон: 6 хуулийн этгээдэд 6 тусгай зөвшөөрөл
11	Тогтоол 11	2019.03.14	Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Өөрчлөлт оруулсан: 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрөл
12	Тогтоол 12	2019.03.14	Хорооны ажлын албаны даргын урамшууллын хэмжээ тогтоох тухай	Шинэчлэн тогтоосон.
13	Тогтоол 13	2019.04.29	Журам батлах тухай (Харилцаа холбооны хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн системийн техникийн нөхцөл, шаардлага тогтоох журам)	Шинээр баталсан.
14	Тогтоол 14	2019.04.29	“Богино зайн радио холбооны тоног төхөөрөмжинд ашиглах радио давтамжийн	Энэхүү баримт бичгийн нэмэлт өөрчлөлтийг ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ



